



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 08 сарын 12 өдөр

Дугаар 84

Улаанбаатар хот

“Молибдены баяжмалын арилжааны гэрээний
стандарт тогтоох, мөрдүүлэх журам батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг, “Монголын хөрөнгийн бирж” хувьцаат компанийн Дүрмийн 5 дугаар зүйлийн 5.7.26 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн “Молибдены баяжмалын арилжааны гэрээний стандарт тогтоох, мөрдүүлэх журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэ тогтоолын 1 дэх хэсэгт заасан “Молибдены баяжмалын арилжааны гэрээний стандарт тогтоох, мөрдүүлэх журам”-ыг дагаж мөрдөх зөвшөөрөл авах асуудлыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу Санхүүгийн зохицуулах хороонд танилцуулж шийдвэрлүүлэхийг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Мөнхбат)-д даалгасугай.

3. Энэ тогтоолын 2 дахь хэсэгт заасны дагуу Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох шийдвэр гарсан өдрөөс эхлэн “Молибдены баяжмалын арилжааны гэрээний стандарт тогтоох, мөрдүүлэх журам”-ыг дагаж мөрдүүлж, журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хороо (Ж.Золзаяа)-нд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ш.БАТ-ЭРДЭНЭ

1526010082

Төлөөлөн удирдах зөвлөлийн
2026 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн
34 дүгээр тогтоолын Хавсралт



**МОЛИБДЕНЫ БАЯЖМАЛЫН АРИЛЖААНЫ ГЭРЭЭНИЙ
СТАНДАРТ ТОГТООХ, МӨРДҮҮЛЭХ ЖУРАМ**

**МОЛИБДЕНЫ БАЯЖМАЛЫН АРИЛЖААНЫ ГЭРЭЭНИЙ СТАНДАРТ ТОГТООХ,
МӨРДҮҮЛЭХ ЖУРАМ**

Нэг.Ерөнхий үндэслэл.....	2
Хоёр.Арилжааны гэрээнд тавигдах шаардлага.....	2
Гурав. Арилжааны гэрээг байгуулсанд тооцох, биржид бүртгүүлэх.....	3
Дөрөв.Арилжааны гэрээний төлбөр, тооцоо.....	3
Тав.Арилжааны гэрээний хэрэгжилт, түүнд тавих хяналт.....	3
Зургаа.Арилжааны гэрээг дуусгавар болгох, түүний үр дагавар.....	3
Долоо.Тээвэрлэлт, хадгалалт, чанарын хяналт.....	4
<i>Тээвэр логистик.....</i>	4
<i>Агуулахын баримт, хадгалалт.....</i>	5
<i>Чанарын хяналт.....</i>	6
Найм.Бусад.....	7

МОЛИБДЕНЫ БАЯЖМАЛЫН АРИЛЖААНЫ ГЭРЭЭНИЙ СТАНДАРТ ТОГТООХ, МӨРДҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг.Ерөнхий үндэслэл

- 1.1. Энэхүү журмаар “Монголын хөрөнгийн бирж” ХК (цаашид “Бирж” гэх)-иар арилжаалсан молибдены баяжмалын арилжааны гэрээний стандартыг тогтоох, хэрэгжилтэд хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулна.
- 1.2. Энэхүү журамд заасан үйл ажиллагаа нь Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх) болон Биржээс баталсан журам, заавар, түүнд нийцүүлэн гаргасан бусад шийдвэрийн хүрээнд хэрэгжинэ.
- 1.3. Энэхүү журмыг Биржийн арилжаанд оролцогчид, Биржийн зах зээлийн бусад оролцогчид дагаж мөрдөнө.

Хоёр.Арилжааны гэрээнд тавигдах шаардлага

- 2.1. Гэрээгээр арилжаалах молибдены баяжмалын 1 багц нь 40 тонн (нойтон метр тонн) байна.
- 2.2. Форвард гэрээний хугацаа 12 сар хүртэл хугацаатай байна.
- 2.3. Спот гэрээний хугацаа 30 буюу түүнээс доош хоногийн хугацаатай байна.
- 2.4. Гэрээний үнийг ам.доллароор илэрхийлэх ба “Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны журам”-д заасны дагуу тогтооно.
- 2.5. Форвард гэрээний хувьд “Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны журам”-д заасны дагуу тогтмол эсхүл хөвөгч үнээр тооцож гэрээний үнийг тохируулж болно.
- 2.6. Арилжааны үед гэрээний үнийг тогтоохдоо худалдагч өөрөөр тогтоогоогүй тохиолдолд хамгийн багадаа тонн тутамд 1 ам.доллароор өсгөх замаар үнийг тогтоосон байна.
- 2.7. Гэрээний дуусгавар болох хугацаа бүтээгдэхүүн нийлүүлж дуусах хугацаанаас хэтрэхгүй байна.
- 2.8. Арилжааны гэрээ болон түүнтэй холбоотой бусад харилцаанд зөвхөн Монгол Улсын хуулийг хэрэглэнэ.

Гурав. Арилжааны гэрээг байгуулсанд тооцох, биржид бүртгүүлэх

- 3.1. Уул уурхайн бүтээгдэхүүний цахим арилжаа амжилттай зохион байгуулагдаж, хэлцэл хийгдсэнээр арилжааны гэрээ байгуулагдсанд тооцож, Биржид бүртгэгдэнэ.
- 3.2. Арилжааны гэрээг байгуулахдаа гэрээнд гарын үсэг зурсан он, сар, өдрийг арилжааны системд хэлцэл амжилттай хийгдсэн өдрөөр тусгана.
- 3.3. Талууд арилжааны гэрээг хэлцэл биелснээс хойш ажлын 5 өдрийн дотор бичгээр үйлдэн баталгаажуулж Биржид ирүүлэх үүрэгтэй. Гэрээг ирүүлээгүй нь гэрээний үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.
- 3.4. Талууд арилжааны гэрээг байгуулахдаа системд хийгдсэн хэлцлийн дагуу байгуулна.
- 3.5. Талуудын байгуулсан арилжааны гэрээ болон түүний нэмэлт гэрээг тухай бүр Биржид бүртгүүлнэ.

Дөрөв. Арилжааны гэрээний төлбөр, тооцоо

- 4.1. Спот гэрээний нийт төлбөрийг худалдан авагч нь хэлцэл амжилттай хийгдсэнээс хойш ажлын 7 өдрийн дотор худалдагчийн дансанд байршуулна.
- 4.2. Форвард гэрээний дагуу хүргэлт хийхээс ажлын 5 өдрийн өмнө худалдан авагч нь тухайн хүргэлтэд ногдох төлбөрийг худалдагчийн дансанд шилжүүлэх ба хүргэлттэй холбоотой нарийвчилсан харилцааг экспортын гэрээнд заасны дагуу зохицуулна.
- 4.3. Арилжааны гэрээний төлбөр, тооцоо гүйцэтгэх бусад харилцааг "Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны төлбөр тооцооны журам"-д заасны дагуу зохицуулна.

Тав. Арилжааны гэрээний хэрэгжилт, түүнд тавих хяналт

- 5.1. Худалдагч эсхүл түүний брокер нь спот, форвард гэрээний хэрэгжилтийн талаарх тайланг Биржид сар бүрийн 10-ны өдөр шинэчлэн ирүүлнэ.
- 5.2. Энэхүү журмын 5.1-т заасан тайланд дараах мэдээллийг тусгасан байна. Үүнд:
 - 5.2.1. бүтээгдэхүүний төлбөр төлсөн баримт;
 - 5.2.2. нийлүүлсэн бүтээгдэхүүний тоо хэмжээ;
 - 5.2.3. тээвэрлэлтийн мэдээлэл;
- 5.3. Бирж нь арилжааны гэрээний хэрэгжилтэд хяналт тавих зорилгоор худалдагч эсхүл түүний брокероос нэмэлт мэдээлэл шаардаж болно.
- 5.4. Арилжааны гэрээний хэрэгжилтийг хангахтай холбоотойгоор бүтээгдэхүүнийг хадгалах, тээвэрлэх, шинжилгээ хийлгэхдээ зөвхөн Биржийн итгэмжлэгдсэн этгээдээр гүйцэтгүүлнэ.

Зургаа. Арилжааны гэрээг дуусгавар болгох, түүний үр дагавар

- 6.1. Арилжааны гэрээ дараах тохиолдолд дуусгавар болно. Үүнд:

- 6.1.1. талууд арилжааны гэрээний үүргийг бүрэн биелүүлсэн;
- 6.1.2. холбогдох хууль тогтоомж болон гэрээнд заасны дагуу гэрээ дуусгавар болох үндэслэл бий болсон.
- 6.2. Гэрээг дуусгавар болгоход баримтлах нөхцөл
 - 6.2.1. Худалдагч, худалдан авагч тал нь гэрээг хугацаанаас нь өмнө дуусгавар болгож байгаа бол түүний үндэслэл, шалтгаан болон дэнчинг гэрээний аль талд шилжүүлэх тухай акт үйлдэж, тус актыг Биржид ирүүлнэ.
 - 6.2.2. Талууд арилжааны гэрээний үүргийг бүрэн биелүүлсэн бол Биржийн “Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны төлбөр тооцооны журам”-д заасан баримт бичгийг Биржид ирүүлнэ.
- 6.3. Гэрээг дуусгавар болгосон, хүчингүйд тооцсоны үр дагавар
 - 6.3.1. Гэрээг дуусгавар болгосон тохиолдолд арилжааны дэнчинтэй холбоотой харилцааг Биржийн “Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны төлбөр тооцооны журам”-аар зохицуулна.
 - 6.3.2. Арилжааны системд хийгдсэн арилжааны гэрээг талууд журамд заасан хугацаанд байгуулаагүй бол тухайн гэрээг цуцлах, дуусгавар болгохтой холбоотой харилцаанд 6.1, 6.2-т заасан зохицуулалт нэгэн адил хэрэглэгдэнэ.

Долоо.Тээвэрлэлт, хадгалалт, чанарын хяналт

Тээвэр логистик

- 7.1. Бүтээгдэхүүнийг итгэмжлэгдсэн агуулах, терминалаас нийлүүлэх цэгт хүргэх ажиллагааг худалдагчтай гэрээ байгуулсан Биржийн итгэмжлэгдсэн тээвэр логикийн үйл ажиллагаа эрхлэгч гүйцэтгэнэ.
- 7.2. Худалдагч нь хүргэлт хийх тээврийн хэрэгслийн дугаар, хүргэлтийн маршрут, бүтээгдэхүүн, тоо хэмжээ, очих хугацааны талаар мэдээллийг итгэмжлэгдсэн агуулах, терминалд бүтээгдэхүүнийг хүргэхээс 3 хоногийн өмнө мэдэгдэнэ.
- 7.3. Худалдан авагчтай байгуулсан гэрээнд өөрөөр заагаагүй бол Худалдагч нь бүтээгдэхүүний гэрээнд заасан газарт хүргэх хүртэл хугацааны тээвэрлэлтийн эрсдэлийг хариуцна.
- 7.4. Тээвэр логикийн үйл ажиллагаа эрхлэгч нь тээвэрлэлтийн гэрээ байгуулсан этгээдийн өмнө хариуцлага хүлээнэ.
- 7.5. Худалдан авагч Биржийн итгэмжлэгдсэн тээвэр логикийн үйл ажиллагаа эрхлэгчийг ашиглахгүйгээр бүтээгдэхүүнийг хүлээн авах бол ачилт хийгдсэнээр хүргэлтийн үйл ажиллагаа дууссан гэж үзнэ.

Агуулахын баримт, хадгалалт

- 7.6. Итгэмжлэгдсэн агуулах, терминал нь бүтээгдэхүүнийг хүлээн авах, ачилт хийж дуусах хүртэл чанар, тоо хэмжээ, аюулгүй байдлыг хариуцна.
- 7.7. Итгэмжлэгдсэн агуулах, терминал нь бүтээгдэхүүнийг хадгалахдаа үндэсний холбогдох стандартад заасан хадгалалтын нөхцөлийг баримтлахаас гадна дараах нөхцөлийг бүрдүүлж ажиллана:
- 7.7.1. камерын хяналтын системийг бүрдүүлсэн байх;
- 7.7.2. бүтээгдэхүүний овоолгын нэршлийн самбартай байх.
- 7.8. Итгэмжлэгдсэн агуулах, терминал нь Биржээр арилжих, арилжсан бүтээгдэхүүнийг хүлээн авч “Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны журам”-ын Хавсралт 3 /цаашид “агуулахын баримт” гэх/-г үйлдэн Биржид ирүүлнэ.
- 7.9. Итгэмжлэгдсэн агуулах, терминал нь итгэмжлэгдсэн лабораториор дээж авхуулах, шинжилгээ хийлгэх үйл ажиллагаанд хамтарч ажиллана. Худалдагч, эсхүл брокер нь шинжилгээний дүнг Биржид ирүүлнэ.
- 7.10. Худалдагч нь худалдан авагчтай байгуулсан гэрээний дагуу бүтээгдэхүүний төлбөрийг хүлээн авсан тухай баримтыг Биржид ирүүлснээр Бирж бүтээгдэхүүнийг хүлээн авах мэдэгдлийг худалдан авагч, эсхүл брокер болон итгэмжлэгдсэн агуулах, терминалд хүргүүлнэ.
- 7.11. Худалдагч нь агуулах, терминалаас ачилт хийхээс ажлын 3 хоногийн өмнө энэ талаар итгэмжлэгдсэн агуулах, терминалд мэдэгдэж, бүтээгдэхүүнийг хүлээн авах этгээдийн биеийн байцаалт, чингэлэг, тээврийн хэрэгсэл болон бүтээгдэхүүн хүлээн авах мэдэгдлийн талаар мэдээллийг урьдчилан итгэмжлэгдсэн агуулах, терминалд хүргүүлнэ.
- 7.12. Итгэмжлэгдсэн агуулах, терминал нь гэрээний дагуу нийлүүлэх бүтээгдэхүүний ачилтыг хийн худалдан авагчид хүлээлгэн өгч акт үйлдэн, итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүнгийн хамт Биржид ирүүлнэ.
- 7.13. Спот гэрээгээр арилжаалах бүтээгдэхүүнийг арилжаа зохион байгуулагдах өдрөөс ажлын 5-аас доошгүй өдрийн өмнө итгэмжлэгдсэн агуулах, терминалд байршуулж, бүртгэсэн байна.
- 7.14. Итгэмжлэгдсэн агуулах, терминал нь бүтээгдэхүүнийг хүлээн авах, хүлээлгэн өгөх бүртгэлийг хөтлөх бөгөөд Бирж нь хяналт, шалгалтын зорилгоор бүртгэл, агуулахын баримтыг тухай бүр шалгах эрхтэй байна.
- 7.15. Агуулахын баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн итгэмжлэгдсэн агуулах, терминал хариуцна.

Чанарын хяналт

- 7.16. Худалдагч нь итгэмжлэгдсэн агуулах, терминалд байршуулсан бүтээгдэхүүнд чанарын шинжилгээ хийлгэх гэрээг Биржийн итгэмжлэгдсэн лабораторитой байгуулна.
- 7.17. Итгэмжлэгдсэн лаборатори нь итгэмжлэгдсэн агуулах, терминалд байршсан бүтээгдэхүүнээс Монгол Улсын холбогдох стандартад заасан аргачлалын дагуу дээж авч шинжилгээ хийнэ.
- 7.18. Итгэмжлэгдсэн агуулах, терминал нь бүтээгдэхүүнийг агуулах, терминалд хүлээн авах болон агуулахаас ачилт хийх үеийн жинг үнэн зөв тооцож, баталгаажуулна.
- 7.19. Итгэмжлэгдсэн лаборатори нь бүтээгдэхүүний чанарын шинжилгээг хийж дууссаны дараа шинжилгээний үр дүнгийн хуудасны эх хувийг агуулах, терминалд, хуулбар хувийг Бирж болон худалдагчид хүргүүлнэ.
- 7.20. Итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний үр дүнгийн хуудаст дээжийн мэдээлэл, сорилт, шинжилгээг гүйцэтгэсэн стандарт, шинжилгээ хийсэн үзүүлэлт, зөвшөөрөгдөх хэмжээ, хэмжих нэгж, үр дүнг тусгасан байна.
- 7.21. Итгэмжлэгдсэн агуулах, терминал нь бүтээгдэхүүнийг агуулах, терминалаас ачих үед итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний үр дүнгийн хуудсыг худалдан авагчид хүлээлгэн өгнө.
- 7.22. Чанарын маргаанаас шалтгаалан агуулах, терминалаас ачилт хийгдээгүй тохиолдолд худалдан авагч нь итгэмжлэгдсэн агуулах, терминалд мэдэгдэн ачилтыг түр хойшлуулж болно. Энэ тохиолдолд худалдан авагч нь Биржээс бүтээгдэхүүн хүлээн авах мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор давтан шинжилгээ хийлгэх хүсэлтийг Биржид гаргана. Давтан шинжилгээ хийлгэх хүсэлтэд агуулах, терминалын нэр, бүтээгдэхүүний байршил, тоо хэмжээ, чанарын үзүүлэлт, холбоо барих хаяг болон шаардлагатай бусад мэдээллийг тусгаж, албан ёсны тамга, тэмдэг дарж баталгаажуулсан байна. Давтан шинжилгээг худалдагч, худалдан авагчийн тохиролцож сонгосон Биржийн итгэмжилсэн шинжилгээний лаборатори гүйцэтгэх бөгөөд давтан шинжилгээний үр дүнгээс хамаарч төлбөрийг худалдан авагч, эсхүл худалдагч хариуцна.
- 7.23. Худалдан авагч нь заасан хугацаанд тогтоосон журмын дагуу давтан шинжилгээ хийлгэх хүсэлт гаргаагүй тохиолдолд агуулах, терминалаас ачсан бүтээгдэхүүний чанарыг хүлээн зөвшөөрсөн гэж үзнэ.
- 7.24. Давтан шинжилгээний дүн болон анхдагч шинжилгээний үр дүн нь Монгол Улсын Стандарт, хэмжил зүйн газраас баталсан холбогдох стандартаар тогтоосон стандарт хазайлтын хүрээнд багтах тохиолдолд шинжилгээний чанар хангалт шаардлага хангасан гэж үзнэ.

- 7.25. Давтан шинжилгээний дүн болон анхдагч шинжилгээний үр дүн нь зөрүүтэй бөгөөд уг зөрүү нь стандарт хазайлтын хүрээнээс илүү гарсан тохиолдолд худалдагч болон худалдан авагч талуудын хооронд байгуулсан экспортын гэрээ буюу худалдах, худалдан авах гэрээгээр зохицуулна.

Найм.Бусад

- 8.1. Арилжааны гэрээ болон энэ журамд заасан үүргийг талууд зөрчсөн тохиолдолд холбогдох хууль, журамд заасны дагуу хариуцлага ногдуулна.
- 8.2. Худалдан авагч нь өөрийн буруугаас гэрээгээр тогтоосон хугацаанд бүтээгдэхүүнийг хүлээн аваагүй тохиолдолд агуулах, терминалын төлбөрийг төлөх бөгөөд агуулахын төлбөрийг дараах байдлаар тооцно:
- 8.2.1. агуулах терминалын төлбөрийг тухайн агуулах, терминалын худалдагчтай байгуулсан гэрээнд тусгагдах нөхцөлөөр;
- 8.2.2. худалдан авагч бүтээгдэхүүнийг хугацаа хожимдуулан хүлээн авснаас хойш тухайн агуулах, терминалын нэхэмжлэхийн дүнгээр.
- 8.3. Итгэмжлэгдсэн агуулах, терминалд байршуулсан бүтээгдэхүүнд чанарын шинжилгээ хийх үйлчилгээний төлбөрийг худалдагч хариуцна.
- 8.4. Энэхүү журмын хэрэгжилтэд Бирж хяналт тавина.

---oOo---



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 08 сарын 12 өдөр

Дугаар 35

Улаанбаатар хот

Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг, "Монголын хөрөнгийн бирж" хувьцаат компанийн Дүрмийн 5 дугаар зүйлийн 5.7.26 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 16 дугаар тогтоолын Нэгдүгээр хавсралтаар баталсан "Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны журам"-д дараах заалтыг нэмсүгэй. Үүнд:

1.1. Журмын 4 дүгээр зүйлийн 4.4¹ дэх хэсэгт "Форвард гэрээгээр арилжаалах зэсийн баяжмал болон молибдены баяжмалын хөвөгч үнийг тооцохдоо бүтээгдэхүүний ачилт хийсэн сарын дундаж үнээр тооцно." гэж нэмэх;

1.2. Журмын 4 дүгээр зүйлийн 4.4² дахь хэсэгт "Зэс, молибдены баяжмалын тогтмол болон хөвөгч үнэтэй худалдах захиалга ирүүлэхдээ дуудах доод үнийг энэ журмын Хавсралт 7-д заасан аргачлалаар тооцсон үнээс багагүй байхаар ирүүлнэ." гэж нэмэх;

1.3. Журмын хавсралтад "Хавсралт 7. Зэс, молибдены баяжмалын дуудах доод үнэ болон хөвөгч үнэтэй гэрээний төлбөрийн үнэ тооцох аргачлал"-ыг нэмэх.

2. "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 16 дугаар тогтоолын Нэгдүгээр хавсралтаар баталсан "Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны журам"-д дараах өөрчлөлтийг оруулсугай. Үүнд:

2.1. Журмын 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэгт "...Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох стандартад заасан төрөл, ангилал, чанарын үзүүлэлтэд нийцсэн байна." гэснийг "...Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох стандартад заасан төрөл, ангилал, чанарын үзүүлэлтэд нийцсэн байна. Хэрэв Биржээр арилжаалах молибдены баяжмалын чанарын үзүүлэлт нь холбогдох стандартад нийцэхгүй тохиолдолд Монгол Улсын Засгийн газраас баталсан биржээр арилжаалах бүтээгдэхүүний нэр төрөл, ангилалд заасан агуулгын хувийг баримтлан арилжаална." гэж өөрчлөх;

1526010089

2.2. Журмын 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэгт "...Биржийн гишүүн брокероор дамжуулан эсхүл өөрөө арилжаанд оролцож болно. Хэрэв худалдан авагч нь өөрөө арилжаанд оролцох тохиолдолд Биржтэй гэрээ байгуулна." гэснийг "...Биржийн гишүүн брокероор дамжуулан эсхүл өөрөө арилжаанд оролцож болно. Хэрэв худалдан авагч нь өөрөө арилжаанд оролцох тохиолдолд Биржтэй гэрээ байгуулах бөгөөд шаардлагатай тохиолдолд тус гэрээг хуульд нийцүүлэн цахимаар байгуулж болно." гэж өөрчлөх;

2.3. Журмын 4 дүгээр зүйлийн 4.4 дэх хэсэгт "...нүүрсний худалдах захиалгын хувьд тогтмол үнэтэй эсхүл индексэд суурилсан үнэтэй ирүүлж болно." гэснийг "...нүүрсний худалдах захиалгын хувьд тогтмол үнэтэй эсхүл индексэд суурилсан үнэтэй, форвард гэрээгээр арилжаалагдах зэсийн баяжмал болон молибдены баяжмалын худалдах захиалгын хувьд тогтмол эсхүл хөвөгч үнэтэй ирүүлж болно." гэж өөрчлөх;

2.4. Журмын 4 дүгээр зүйлийн 4.5 дахь хэсэгт "...энэхүү журмын Хавсралт 6-д заасан аргачлалыг баримтална." гэснийг "...энэхүү журмын Хавсралт 6-д, зэс, молибдены баяжмалын захиалгыг хөвөгч үнэтэй ирүүлэх бол Хавсралт 7-д заасан аргачлалыг тус тус баримтална." гэж өөрчлөх;

2.5. Журмын 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт "...арилжааг ажлын өдрүүдэд 10:00-17:00 цагийн хооронд зохион байгуулна." гэснийг "...арилжааг ажлын өдрүүдэд 10:00-12:00, 14:00-16:00 цагийн хооронд зохион байгуулна." гэж өөрчлөх;

2.6. Журмын Хавсралт 6-аар баталсан "Индексийн хөдөлгөөн тооцох аргачлал"-д арилжааны системд хэлцэл хийгдсэн өдөр нь хуанлийн сарын 1-15-ны өдөр бол тухайн сар болон дараагийн сарын гэрээний үнийг тогтмол үнээр, 16-31-ний өдөр бол тухайн сар болон дараагийн 2 сарын гэрээний үнийг тогтмол үнээр тооцохоор нэмэлт, өөрчлөлт оруулах.

3. Энэ тогтоолын 2.2-т заасны дагуу Биржтэй цахим гэрээ байгуулах аргачлалыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу боловсруулан Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд танилцуулан баталж хэрэгжүүлэхийг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

4. Энэ тогтоолын 1 болон 2 дахь хэсэгт заасан "Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны журам"-ын нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөх зөвшөөрөл авах асуудлыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу Санхүүгийн зохицуулах хороонд танилцуулж шийдвэрлүүлэхийг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Мөнхбат)-д даалгасугай.

5. Энэ тогтоолын 4 дахь хэсэгт заасны дагуу Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох шийдвэр гарсан өдрөөс эхлэн "Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны журам"-ын нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдүүлж, журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

6. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хороо (Ж.Золзаяа)-нд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ш.БАТ-ЭРДЭНЭ

Төлөөлөн удирдах зөвлөлийн
2025 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн
16 дугаар тогтоолын Нэгдүгээр хавсралт



**“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БИРЖИЙН АРИЛЖААНЫ ЖУРАМ**
/Шинэчилсэн найруулга/

*/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн 35 дугаар
тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулсан./*

УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БИРЖИЙН АРИЛЖААНЫ ЖУРАМ

Нэг.Ерөнхий зүйл.....	2
Хоёр.Биржээр арилжаалах уул уурхайн бүтээгдэхүүн.....	2
Гурав.Худалдагч, худалдан авагчийг бүртгэх, бүртгэхээс татгалзах.....	2
Дөрөв.Захиалга хүлээн авах, бүртгэх, бүртгэхээс татгалзах.....	3
Тав.Арилжааг зохион байгуулах.....	5
Зургаа.Хэлцлийн тайлан.....	6
Долоо.Арилжааны мэдээллийн ил тод байдал.....	6
Найм.Арилжааг зогсоох, цуцлах, хүчингүй болгох.....	6
Ес.Бусад.....	7
“Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны журам”-ын.....	8
Хавсралт 1.	8
“Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны журам”-ын.....	10
Хавсралт 2.	10
“Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны журам”-ын.....	16
Хавсралт 3.	16
“Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны журам”-ын.....	17
Хавсралт 4.	17
“Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны журам”-ын.....	18
Хавсралт 5.	18
Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны журам”-ын	18
Хавсралт 6.	18
Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны журам”-ын	22
Хавсралт 7.	22

УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БИРЖИЙН АРИЛЖААНЫ ЖУРАМ

Нэг.Ерөнхий зүйл

- 1.1. Энэхүү журмаар "Монголын хөрөнгийн бирж" ХК (цаашид "Бирж" гэх)-ийн уул уурхайн бүтээгдэхүүний спот, форвард гэрээг арилжаалах захиалгыг хууль тогтоомжийн хүрээнд бүртгэх, арилжааг зохион байгуулах, мэдээллийн ил тод байдлыг хангахтай холбоотой харилцааг зохицуулна.
- 1.2. Уул уурхайн бүтээгдэхүүнд суурилсан фьючерс, опцион санхүүгийн хэрэгслийн арилжааг энэ журмаар зохицуулахгүй.
- 1.3. Энэхүү журмаар зохицуулаагүй бусад харилцааг Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, Улсын Их Хурлын тогтоол, Засгийн газрын тогтоол, захиргааны хэм хэмжээний акт, Санхүүгийн зохицуулах хороо (цаашид "Хороо" гэх) болон Биржээс баталсан бусад журам, заавраар зохицуулна.
- 1.4. Энэхүү журмыг Бирж, Биржийн арилжаанд оролцогчид, Биржийн зах зээлийн бусад оролцогчид дагаж мөрдөнө.
- 1.5. Биржээр арилжаалсан бүтээгдэхүүнд татвар, төлбөр, хураамжийг хууль тогтоомжийн дагуу ногдуулна.

Хоёр.Биржээр арилжаалах уул уурхайн бүтээгдэхүүн

- 2.1. Бирж нь Засгийн газраас баталсан уул уурхайн бүтээгдэхүүний арилжааг зохион байгуулна.
- 2.2. Биржээр арилжаалах уул уурхайн бүтээгдэхүүн нь Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох стандартад заасан төрөл, ангилал, чанарын үзүүлэлтэд нийцсэн байна. Хэрэв Биржээр арилжаалах молибдены баяжмалын чанарын үзүүлэлт нь холбогдох стандартад нийцэхгүй тохиолдолд Монгол Улсын Засгийн газраас баталсан биржээр арилжаалах бүтээгдэхүүний нэр төрөл, ангилалд заасан агуулгын хувийг баримтлан арилжаална.
Энэ хэсгийг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн 35 дугаар тогтоолоор өөрчилсөн./
- 2.3. Биржээр арилжаалагдсан бүтээгдэхүүний чанарын шаардлагыг худалдагч хариуцах бөгөөд бүтээгдэхүүний чанарыг өөрчлөхгүй байхад шаардагдах арга хэмжээг авч ажиллана.
- 2.4. Худалдагч нь зөвхөн бэлэн байгаа уул уурхайн бүтээгдэхүүнийг спот арилжаагаар арилжаалах бөгөөд тухайн бүтээгдэхүүнийг итгэмжлэгдсэн агуулахад байршуулж, итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээ хийлгүүлсэн байна.
- 2.5. Уул уурхайн бүтээгдэхүүн тус бүрийг багц (лот)-аар илэрхийлэх ба тухайн багцад ногдох уул уурхайн бүтээгдэхүүний хэмжээ, түүнтэй холбоотой харилцааг холбогдох журмаар зохицуулна.
- 2.6. ~~Биржээр арилжаалах уул уурхайн бүтээгдэхүүний 50 буюу түүнээс дээш хэмжээний багцыг их хэмжээний багцад тооцно.~~
/Энэ хэсгийг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 48 дугаар тогтоолоор хассан./

Гурав.Худалдагч, худалдан авагчийг бүртгэх, бүртгэхээс татгалзах

- 3.1. Худалдан авагч нь Биржид бүртгүүлэхээс өмнө өөрийн мэдээллийг Биржийн арилжааны системд оруулж, харилцагчийн код авах ба тухайн код нь худалдан авагчийг таних, дахин давтагдашгүй код байна.
- 3.2. Журмын хавсралт 5-д заасан шаардлагыг хангаж, баримт бичгийг Биржид ирүүлсэн худалдан авагч нь Биржийн гишүүн брокероор дамжуулан эсхүл өөрөө арилжаанд оролцож болно. Хэрэв худалдан авагч нь өөрөө арилжаанд оролцох тохиолдолд

Биржтэй гэрээ байгуулах бөгөөд шаардлагатай тохиолдолд тус гэрээг хуульд нийцүүлэн цахимаар байгуулж болно.

/Энэ хэсгийг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн 35 дугаар тогтоолоор өөрчилсөн./

- 3.3. Бирж дараах шаардлагыг хангасан худалдагчийг бүртгэнэ. Үүнд:
- 3.3.1. ашигт малтмал олборлогч этгээдийн хувьд ашигт малтмал ашиглалтын хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөлтэй Монгол Улсын хуулийн этгээд байх;
 - 3.3.2. баяжуулах, боловсруулах үйлдвэрийн хувьд ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээтэй байх;
 - 3.3.3. тухайн чиглэлээр нэгээс доошгүй жил үйл ажиллагаа явуулсан байх;
 - 3.3.4. боловсруулах, баяжуулах үйлдвэрийн баталгаажсан техник, эдийн засгийн үзүүлэлттэй байх;
- 3.4. Худалдагчаар бүртгүүлэх хуулийн этгээд өөрөө эсхүл түүний брокер нь энэхүү журмын хавсралт 4-д заасан баримт бичгийг Биржид ирүүлнэ.
- 3.5. Бирж худалдагчаар бүртгүүлэх хүсэлтийг холбогдох баримт бичгийн хамт хүлээн авч, Захирлуудын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, журмын шаардлага хангасан хуулийн этгээдтэй гэрээ байгуулна.
- 3.6. Дараах тохиолдолд худалдагч, худалдан авагчийг бүртгэхээс татгалзана. Үүнд:
- 3.6.1. энэхүү журамд заасан шаардлагыг хангаагүй;
 - 3.6.2. хүчин төгөлдөр бус баримт бичиг ирүүлсэн;
 - 3.6.3. журамд заасан ирүүлбэл зохих баримт бичгийг Биржээс шаардсан хугацаанд ирүүлээгүй;
 - 3.6.4. холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд заасан бусад үндэслэл.
- 3.7. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжаанд зөвхөн Биржтэй эсхүл Биржийн гишүүн брокертой гэрээ байгуулсан хуулийн этгээд худалдагч, худалдан авагчаар оролцоно.

Дөрөв.Захиалга хүлээн авах, бүртгэх, бүртгэхээс татгалзах

Худалдах захиалга, түүнийг хүлээн авах

- 4.1. Худалдагч нь Биржид худалдах захиалга ирүүлэхээс өмнө Биржийн итгэмжлэгдсэн тээвэр, лаборатори, агуулах, терминалтай гэрээ байгуулсан байна.
- 4.2. Худалдагч эсхүл түүний брокер нь Биржээр арилжаалах бүтээгдэхүүний захиалгыг дараах баримт бичгийн хамт арилжаа зохион байгуулагдахаас ажлын 7-оос доошгүй өдрийн өмнө Биржид ирүүлнэ. Үүнд:
- /Энэ хэсгийг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 48 дугаар тогтоолоор өөрчилсөн./*
- 4.2.1. энэхүү журмын Хавсралт 1-т заасан “Уул уурхайн бүтээгдэхүүн худалдах захиалга”;
 - 4.2.2. энэхүү журмын Хавсралт 2-д заасан “Уул уурхайн бүтээгдэхүүний арилжааны зарын маягт”-ыг арилжааны системд үнэн зөв, бүрэн гүйцэт бөглөх;
 - 4.2.3. спот гэрээний хувьд энэхүү журмын Хавсралт 3-т заасан агуулахын баримт;
 - 4.2.4. бүтээгдэхүүний итгэмжлэгдсэн лабораторийн хүчин төгөлдөр шинжилгээний дүгнэлт;
 - 4.2.5. арилжаалах бүтээгдэхүүний дуудах доод үнийн тооцоолол;
 - 4.2.6. Бүртгэх үйлчилгээний хөлс төлсөн баримт.
- 4.3. Бирж нь захиалгатай холбоотой шаардлагатай нэмэлт мэдээлэл, тодруулга, баримт бичгийг худалдагч эсхүл түүний брокероос хугацаа тогтоон, гаргуулан авч болно.
- 4.4. Форвард гэрээгээр арилжаалагдах нүүрсний худалдах захиалгын хувьд тогтмол үнэтэй эсхүл индексэд суурилсан үнэтэй, форвард гэрээгээр арилжаалагдах зэсийн баяжмал болон молибдены баяжмалын худалдах захиалгын хувьд тогтмол эсхүл хөвөгч үнэтэй ирүүлж болно.
- /Энэ хэсгийг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 08 дугаар сарын 12 -ны өдрийн 35 дугаар тогтоолоор өөрчилсөн./*
- 4.4¹. Форвард гэрээгээр арилжаалах зэсийн баяжмал болон молибдены баяжмалын хөвөгч үнийг тооцохдоо бүтээгдэхүүний ачилт хийсэн сарын дундаж үнээр тооцно.
- /Энэ хэсгийг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 08 дугаар сарын 12 -ны өдрийн 35 дугаар тогтоолоор нэмсэн./*

- 4.4². Зэс, молибдены баяжмалын тогтмол болон хөвөгч үнэтэй худалдах захиалга ирүүлэхдээ дуудах доод үнийг энэ журмын Хавсралт 7-д заасан аргачлалаар тооцсон үнээс багагүй байхаар ирүүлнэ.
/Энэ хэсгийг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн 35 дугаар тогтоолоор нэмсэн./
- 4.5. Хэрэв нүүрсний форвард гэрээний захиалгыг индексэд суурилсан үнэтэй ирүүлэх бол энэхүү журмын Хавсралт 6-д, зэс, молибдены баяжмалын захиалгыг хөвөгч үнэтэй ирүүлэх бол Хавсралт 7-д заасан аргачлалыг тус тус баримтална.
/Энэ хэсгийг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн 35 дугаар тогтоолоор өөрчилсөн./
- 4.6. Бирж нь худалдах захиалгыг энэхүү журамд заасан баримт бичгийн хамт хүлээн авснаас хойш ажлын 2 өдрийн дотор шалгаж, бүртгэх эсэхийг шийдвэрлэнэ.
- 4.7. Худалдах захиалгыг бүртгэхдээ тухайн арилжаа зохион байгуулагдах өдөр, цагийг арилжааны төлөвлөгөө, хуваарьтай уялдуулж өөрчлөн бүртгэж болно. Ингэхдээ худалдагч эсхүл түүний брокертой зөвшилцөх бөгөөд хэрэв зөвшилцөлд хүрээгүй бол тухайн захиалгыг бүртгэхээс татгалзах үндэслэл болно.
- 4.8. Худалдах захиалга нь энэхүү журамд заасан шаардлагыг хангасан тохиолдолд Биржийн Гүйцэтгэх захирлын тушаалаар бүртгэж, арилжааны зарыг олон нийтэд арилжаа зохион байгуулагдах өдрөөс ажлын 5-аас доошгүй өдрийн өмнө Биржийн албан ёсны цахим хуудсаар дамжуулан мэдээлнэ.
/Энэ заалтыг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 48 дугаар тогтоолоор өөрчилсөн./
- 4.9. Дараах тохиолдолд Бирж худалдах захиалгыг бүртгэхээс татгалзана. Үүнд:
- 4.9.1. захиалгын мэдээлэл болон бүрдүүлбэр дутуу;
 - 4.9.2. Биржээс шаардсан захиалгатай холбоотой нэмэлт мэдээлэл, баримт бичгийг ирүүлээгүй;
 - 4.9.3. гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа биелүүлээгүй;
 - 4.9.4. тухайн компанийг арилжаанд оролцох эрхийг түр хязгаарласан, хассан;
 - 4.9.5. холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд заасан бусад үндэслэл.
- 4.10. Бирж нь энэхүү журмын 4.9-т заасан үндэслэлээр худалдах захиалгыг бүртгэхээс татгалзсан тохиолдолд энэ тухай худалдагч эсхүл түүний брокерт нэн даруй мэдэгдэнэ.
- 4.11. Худалдагч Биржид ирүүлсэн худалдах захиалгын мэдээллийг зөрүүтэй ирүүлсэн тохиолдолд түүнээс үүсэх үр дагаврыг худалдагч өөрөө хариуцна.
- 4.12. Хэрэв худалдагч брокероор дамжуулан худалдах захиалгыг Биржид ирүүлсэн тохиолдолд захиалгын үнэн зөвийг брокер хариуцна.

Биржид бүртгэгдсэн худалдах захиалгад өөрчлөлт оруулах, цуцлах

- 4.13. Уул уурхайн бүтээгдэхүүний зах зээлийн үнэ буурсан эсхүл өссөн тохиолдолд арилжаа зохион байгуулагдахаас ажлын 1-ээс доошгүй өдрийн өмнө дуудах доод үнийг өөрчлөх хүсэлт ирүүлж болно.
/Энэ хэсгийг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 48 дугаар тогтоолоор өөрчилсөн./
- 4.14. Бирж нь 4.13-т заасан хүсэлтийг харгалзан, Гүйцэтгэх захирлын тушаалаар тухайн захиалгад өөрчлөлт оруулж болох бөгөөд хэрэв өөрчлөлт оруулсан бол олон нийтэд нэн даруй Биржийн албан ёсны цахим хуудсаар мэдээлнэ.
- 4.15. Дараах тохиолдолд Бирж бүртгэгдсэн захиалгыг цуцална. Үүнд:
- 4.15.1. эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас шаардсан;
 - 4.15.2. гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлаас тухайн арилжаа явагдах боломжгүй болсон талаарх баримтыг Худалдагч ирүүлсэн.
- 4.16. Хэрэв Биржээс захиалгыг цуцалсан бол энэ талаар биржийн арилжаанд оролцогчдод нэн даруй мэдэгдэнэ.
- 4.17. Захиалгыг цуцлах шалтгаан болсон нөхцөл байдал арилсан тохиолдолд тухайн худалдагчийн шинээр ирүүлсэн захиалгыг бүртгэж болно.

Худалдан авагч арилжаанд оролцох

- 4.18. Худалдан авагч нь өөрөө эсхүл Биржийн гишүүн брокероор дамжуулан арилжаанд

- оролцоно.
- 4.19. Худалдан авагч эсхүл түүний брокер нь худалдан авах захиалга өгөх, арилжаанд оролцохдоо дараах үүргийг хүлээнэ. Үүнд:
- 4.19.1. Биржээс олгосон арилжааны системд хандах эрхээр нэвтэрч арилжаанд оролцох;
 - 4.19.2. өөрийн тоног төхөөрөмж, программ хангамжийн бэлэн байдлыг хангах;
 - 4.19.3. арилжааны системтэй холбоотой ямар нэг доголдол илэрвэл Биржид яаралтай мэдэгдэж шаардлагатай арга хэмжээ авч ажиллах;
 - 4.19.4. арилжаанд оролцох заавар, зөвлөмж болон шаардлагатай хууль тогтоомж биржийн дүрэм, журамтай сайтар танилцаж, дагаж мөрдөх;
 - 4.19.5. Биржээс мэдээлсэн арилжаа болон худалдах захиалгатай холбоотой мэдээ, мэдээлэлтэй Биржийн цахим хуудсаар дамжуулан тогтмол танилцах;
/Энэ заалтыг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 48 дугаар тогтоолоор нэмсэн./
- 4.20. Худалдан авагч эсхүл түүний брокер нь арилжааны системд нэвтрэх эрхийг бусдад дамжуулахгүй, шилжүүлэхгүй байх, бусад этгээд олж авах нөхцөлийг бүрдүүлэхгүй байхаар нууцлалыг хадгалах үүрэгтэй. Энэхүү үүргээ зөрчсөнөөс арилжааны системд нэвтрэх эрхгүй этгээд нэвтэрсэн, зохих зөвшөөрөлгүйгээр арилжааны системд үйлдэл хийснээс үүсэх хохирол, бусад үр дагаврыг Бирж хариуцахгүй.
- 4.21. Худалдан авагч эсхүл түүний брокер нь арилжааны явцад захиалгын санд оруулах худалдан авах үнийн саналын үнэн зөв, түүнээс үүсэх үр дагаврыг бүрэн хариуцна.
- 4.22. Худалдан авагч эсхүл түүний брокерын буруутай үйлдэл, эс үйлдэхүйн улмаас үнийн саналыг захиалгын санд буруу оруулсан нь тухайн үнээр хийгдсэн хэлцэл, байгуулагдсан гэрээг цуцлах үндэслэл болохгүй.
- 4.23. Брокер нь худалдан авагчийн захиалга, түүний мэдээллийн нууцлалыг чандлан хадгалж аливаа ашиг олох зорилгоор ашиглах, бусад этгээдэд тараах, олж авах нөхцөлийг бүрдүүлэхийг хориглоно.

Тав.Арилжааг зохион байгуулах

- 5.1. Бирж арилжааг ажлын өдрүүдэд 10:00-12:00, 14:00-16:00 цагийн хооронд зохион байгуулна.
/Энэ хэсгийг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 08 дугаар сарын 12 -ны өдрийн 35 дугаар тогтоолоор өөрчилсөн./
- 5.2. Бирж нь уул уурхайн бүтээгдэхүүний захиалгыг худалдагч эсхүл түүний брокероос ирүүлсэн доод үнээс эхлэн цахимаар үнэ хаялцуулан нээлттэйгээр зохион байгуулна.
- 5.3. Арилжааны дуудах доод үнийн хамгийн бага өөрчлөлтийн хэмжээ худалдагчийн ирүүлсэн захиалгад өөрөөр тогтоогоогүй тохиолдолд тонн тутамд 0.3 ам.доллар эсхүл 3 юань байна.
- 5.4. Арилжаа нь дараах 3 үе шаттайгаар явагдана. Үүнд:
- 5.4.1. захиалга бүртгэх үе;
 - 5.4.2. дуудах үе;
 - 5.4.3. хэлцэл хийгдэх үе.
- 5.5. Худалдан авах захиалга бүртгэх үе нь 60 минутын хугацаанд үргэлжлэх бөгөөд энэ үед худалдан авах захиалгыг арилжааны системд бүртгүүлж, түүнийг өөрчилж эсхүл цуцалж болно.
- 5.6. Захиалга бүртгэх болон дуудах үед Биржийн арилжааны систем худалдан авах захиалгыг хамгийн өндөр үнээс бага үнэ рүү эрэмбэлэх бөгөөд ижил үнэтэй захиалгуудын хувьд цаг хугацааны дарааллаар эрэмбэлнэ.
- 5.7. Худалдан авагч нь захиалга бүртгэх үед захиалга оруулаагүй, эсхүл оруулсан боловч цуцалсан бол дуудах үед захиалга оруулах боломжгүй.
- 5.8. Худалдан авах захиалга бүртгэх үе дууссаны дараа дуудах үе нь 1 минут үргэлжлэх бөгөөд энэ үед бүртгүүлсэн захиалгын үнийг бууруулах болон цуцлах боломжгүй.
- 5.9. Дуудах үед хамгийн дээд үнэ шинэчлэгдэх тохиолдол бүрд дуудах үе дахин 1 минутын хугацаагаар сунгагдана.
- 5.10. Дуудах үеийн 1 минутын хугацаанд дээд үнийг шинэчлэх захиалга оруулаагүй тохиолдолд хамгийн дээд үнийн саналаар хэлцэл хийгдэнэ.
- 5.11. Энэхүү журмын 5.10-т заасны дагуу хэлцэл хийгдсэнээр арилжааны гэрээ

байгуулагдсанд тооцож тухайн арилжаа дуусгавар болно.

- 5.12. Брокер нь өөрийн буруутай үйлдэл, эс үйлдэхүйгээр, эсхүл түүний системийн хэвийн бус ажиллагаанаас шалтгаалж худалдан авагчийн өгсөн захиалгаас өөр захиалга арилжааны системд бүртгүүлсний улмаас хэлцэл хийгдэж, гэрээ байгуулагдсан бол тухайн арилжааны гэрээний үүрэг хариуцлагыг брокер хүлээнэ.

Зургаа.Хэлцлийн тайлан

- 6.1. Бирж нь арилжаа зохион байгуулагдаж дууссанаас хойш тухай бүр арилжааны мэдээг өөрийн албан ёсны цахим хуудсаар мэдээлэх бөгөөд арилжаа амжилттай хийгдсэн тохиолдолд баталгаажсан хэлцлийн тайланг худалдагч, худалдан авагч эсхүл тэдгээрийн брокерт цахимаар хүргүүлнэ.Үүнд:
- 6.1.1. хэлцэл хийгдсэн үнэ, хэлцлийн дугаар;
 - 6.1.2. худалдан авахаар шалгарсан хуулийн этгээдийн албан ёсны нэр, хаяг, утасны дугаар, и-мэйл хаяг;
 - 6.1.3. худалдан авагч талтай арилжааны гэрээг баталгаажуулах хугацаа (ажлын 5 өдрийн дотор);
 - 6.1.4. арилжааны гэрээтэй болон төлбөр тооцоотой холбоотой бусад мэдээлэл.
- 6.2. Худалдан авагчид хүргүүлэх баталгаажсан хэлцлийн тайланд дараах мэдээлэл тусгагдсан байна. Үүнд:
- 6.2.1. худалдагчийн албан ёсны нэр, хаяг, холбоо барих утасны дугаар, и-мэйл хаяг;
 - 6.2.2. худалдагч талтай арилжааны гэрээг цаасаар баталгаажуулах хугацаа, хэлцлийн төлбөр төлөх нөхцөл, арилжааны шимтгэл төлөхтэй холбоотой мэдээлэл;
- 6.3. Арилжааны төлбөр тооцоог гүйцэтгэхтэй холбоотой харилцааг Биржийн "Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны төлбөр тооцооны журам"-аар зохицуулна.

Долоо.Арилжааны мэдээллийн ил тод байдал

- 7.1. Бирж нь арилжааны болон ханшийн мэдээллийн сан бүрдүүлж, олон нийтэд арилжааны систем болон цахим хуудсаар дамжуулан тогтмол мэдээлнэ.
- 7.2. Арилжааны мэдээнд дараах мэдээлэл тусгагдсан байна. Үүнд:
- 7.2.1. арилжаа зохион байгуулагдсан он, сар, өдөр;
 - 7.2.2. арилжаанд оролцсон нийт худалдан авах санал гаргагчдын тоо;
 - 7.2.3. худалдагч хуулийн этгээдийн нэр, албан ёсны хаяг;
 - 7.2.4. захиалгын бүртгэлийн дугаар;
 - 7.2.5. доод үнэ;
 - 7.2.6. хэлцэл хийгдсэн үнэ;
 - 7.2.7. гэрээний нийт үнийн дүн;
 - 7.2.8. үнийн өсөлтийн хувь;
 - 7.2.9. арилжсан уул уурхайн бүтээгдэхүүний төрөл, ангилал, чанарын үзүүлэлт.
- 7.3. Бирж нь арилжааны үнэ, хэмжээ, бүтээгдэхүүний төрөл, ангилал, арилжаа зохион байгуулагдсан он, сар, өдөр зэрэг үзүүлэлтээр өдөр, долоо хоног, сар, жилээр тогтмол мэдээлнэ.
- 7.4. Худалдагч нь төлбөр тооцоонд цахим төлбөрийн баримт үйлдэж, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд хэлцлийг бүртгэнэ.

Найм.Арилжааг зогсоох, цуцлах, хүчингүй болгох

- 8.1. Бирж нь дараах тохиолдолд арилжааг зогсооно. Үүнд:
- 8.1.1. арилжааны явцад гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн улмаас тухайн арилжааг зохион байгуулах боломжгүй болсон;
 - 8.1.2. улсын байцаагчийн албан шаардлагын дагуу.
- 8.2. Энэхүү журмын 8.1.1-т заасан арилжааг зогсоох нөхцөл байдал арилсан бол арилжааг хэвийн үргэлжлүүлнэ. Уг нөхцөл байдал арилаагүй бол арилжааг цуцалж, энэ тухай арилжаанд оролцогчдод нэн даруй цахимаар мэдэгдэж, дахин зохион байгуулна.
- 8.3. Журмын 8.1.2-т заасны дагуу зогсоосон арилжааны албан шаардлага цуцлагдсан тохиолдолд арилжааг дахин зохион байгуулна. Хэрэв цуцлах шийдвэр гаргасан бол тухайн арилжааг цуцалж, энэ тухай арилжаанд оролцогчдод нэн даруй цахимаар мэдэгдэнэ.

- 8.4. Бирж нь журмын 8.2, 8.3-т заасны дагуу арилжааг дахин зохион байгуулах тохиолдолд энэ тухай мэдээллийг өөрийн цахим хуудсаар мэдээлнэ.

Ес.Бусад

- 9.1. Энэхүү журмыг зөрчсөн арилжаанд оролцогчийн үйлдэл нь гэмт хэргийн болон зөрчлийн шинжгүй бол холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд заасан хариуцлага хүлээлгэнэ.
- 9.2. Энэхүү журмаар зохицуулаагүй харилцааг Хороотой зөвшилцсөний үндсэн дээр хуульд нийцүүлэн шийдвэрлэнэ.
- 9.3. Энэхүү журмын хэрэгжилтэд Бирж хяналт тавина.

---oOo---

УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮН ХУДАЛДАХ ЗАХИАЛГА

Огноо:.....	Дугаар:.....	Улаанбаатар хот
-------------	--------------	-----------------

Бид [уул уурхайн бүтээгдэхүүн худалдагч аж ахуйн нэгж, түүнийг төлөөлж] энэхүү маягт, түүнд хавсаргасан баримт бичгийн үнэн зөвийг бүрэн хариуцах бөгөөд худалдан авагчид хүргэвэл зохих мэдээллийг үнэн зөв, бүрэн тусгасан болно.

1.	Уул уурхайн бүтээгдэхүүний худалдагчийн мэдээлэл	
1.1	Оноосон нэр:	
1.2	Бүртгэлтэй улс, улсын бүртгэлийн дугаар:	
1.3	Регистрийн дугаар:	
1.4	Үйл ажиллагааны чиглэл:	
1.5	Оршин байх албан ёсны хаяг: <i>/Монгол Улсад төлөөлөгчийн газартай бол түүний хаягийг мөн бичнэ/</i>	
1.6	Шуудангийн болон цахим шуудангийн хаяг, холбоо барих утас:	
1.7	Энэхүү маягттай холбоотой асуудлыг хариуцах этгээдийн нэр, албан тушаал, хаяг, холбоо барих утас:	
1.8	Компанийн одоогийн гүйцэтгэх удирдлага эсхүл удирдлагын баг /байхгүй бол эрх бүхий албан тушаалтан/-ийн гишүүдийн товч мэдээлэл:	
1.9	Төлбөр, тооцоог гүйцэтгэх банк, дансны мэдээлэл:	
1.10	Худалдан авагчид хүргэвэл зохих нэмэлт мэдээлэл:	
2.	Арилжаалагдах бүтээгдэхүүний мэдээлэл	
2.1	Бүтээгдэхүүний багц, тоо хэмжээ(тонн):	 багц буюу нийт тонн
2.2	Бүтээгдэхүүний төрөл ангилал:	
2.3	Бүтээгдэхүүний чанарын үзүүлэлт: <i>/Стандарт чанарын үзүүлэлтүүд/</i>	
2.4	Арилжаа зохион байгуулагдах огноо:	
2.5	Дуудах доод үнэ, валютын төрөл:	
2.6	Дуудах үед үнэ өсгөх хамгийн Бага үнийн дүн, валют (tick size):	
2.7	Дэнчингийн хэмжээ:	
2.8	Дэнчин байршуулах дансны дугаар:	
2.9	Чанарын шинжилгээ хийсэн итгэмжлэгдсэн лабораторийн мэдээлэл: <i>/нэр, хаяг, холбоо барих утас/</i>	
2.10	Итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний товч дүгнэлт, чанарын	Жишиг үзүүлэлт:

	үзүүлэлт:	Хэмжигдэхүүн	Чанарын үзүүлэлт /Өөрчлөлтийн хувь*/
		Үзүүлэлт 1	
		Үзүүлэлт 2	
		Үзүүлэлт 3	
		Үзүүлэлт 4	
2.11	Бүтээгдэхүүн нийлүүлэх цэг		
2.12	Бүтээгдэхүүн хүргэж өгөх сүүлийн хугацаа /огноо/:		
2.13	Бүтээгдэхүүн нийлүүлэх хуваарь		
	Нийлүүлэх хугацаа		
	Төлбөр төлөх хугацаа		
	Нийлүүлэх Хэмжээ /тонн/		
2.14	Тогтмол үнэтэй, индексэд суурилсан үнэтэй эсхүл хөвөгч үнэтэй захиалга		

/Бид энэхүү маягт болон түүнд хавсаргасан баримт, бичгийг төрийн эрх бүхий байгууллага болон олон нийтэд мэдээллэхийг зөвшөөрч байна/

Бүтээгдэхүүн арилжаалах захиалгыг баталгаажуулсан:

Овог, нэр:

Албан тушаал:

“.....” ХХК/ХК/ТӨҮГ-ийн

.....

Гарын үсэг:

(Тамга/тэмдэг)

ТУСГАЙ ТЭМДЭГЛЭЛ /зөвхөн Биржийн албан хэрэгцээнд/

Захиалга хүлээн авсан ажилтны овог, нэр:	Захиалга хүлээн авсан огноо, цаг, минут:	Захиалга, түүнд хавсаргасан баримтын тоо /нүүрээр/:

---oOo---

УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ФОРВАРД ГЭРЭЭНИЙ АРИЛЖААНЫ ЗАР

1	Худалдагч этгээдийн нэр	
2	Арилжаа зохион байгуулагдах огноо, цаг	
3	Уул уурхайн бүтээгдэхүүний төрөл, ангилал	
4	Чанарын үзүүлэлт	Хэмжигдэхүүн
		Чанарын үзүүлэлт
5	Багцын тоо, нийт хэмжээ	
6	Дуудах доод үнэ, валютын төрөл	
7	Тогтмол үнэтэй, индексэд суурилсан үнэтэй эсхүл хөвөгч үнэтэй захиалга эсэх	
8	Чанарын зөрүүнд тооцох үнийн нэмэгдэл, бууралт байгаа эсэх, тооцох аргачлал	
9	Дуудах үед үнэ өсгөх хамгийн бага дүн	
10	Гэрээ дуусгавар болох хугацаа	
11	Хүргэлт хийх хугацаа, нөхцөл /хэсэгчилж хүргэлт хийх тохиолдолд хүргэлтийн хуваарь/	
12	Бүтээгдэхүүн нийлүүлэх цэг	
13	Тээвэрлэлтийн төрөл	
14	Дэнчингийн хэмжээ	
15	Дэнчин байршуулах банкны дансны мэдээлэл, валютын төрөл	
16	Худалдан авагчид хүргэвэл зохих нэмэлт мэдээлэл	
17	Биржийн мэдээллийн ажилтантай холбоо барих утасны дугаар	

БҮТЭЭГДЭХҮҮН НИЙЛҮҮЛЭХ ХУВААРЬ

Бүтээгдэхүүн нийлүүлэх хугацаа				
Төлбөр төлөх хугацаа				
Нийлүүлэх хэмжээ /тонн/				

Энэхүү маягтад тусгасан мэдээллийн үнэн зөвийг худалдагч тал бүрэн хариуцна. Хэрэв Монгол, Англи, Хятад хэл дээрх зарын мэдээлэл хоорондоо зөрөх тохиолдолд Монгол хэл дээрх зарыг зөв гэж үзнэ.

---oOo---

TRADING ADVERTISEMENT FOR FORWARD CONTRACT OF MINING PRODUCTS

1	Seller's name		
2	Auction date and, time		
3	Type and classification of mining product		
4	Quality estimation	Measurements	Quality index
5	Number of lots and, total weight		
6	Bid opening bid price and, currency type		
7	Fixed/ floating/ index-based pricing		
8	minimum amount to increase the bid price during the auction /tick size/		
9	Termination date of the contract		
10	The delivery date and, type of incoterms		
11	point of delivery		
12	Transportation type		
13	Amount of collateral		
14	Bank account info for collateral and, its currency type		
15	Additional information for buyers		
16	contact information for further enquiries		

Product delivery schedule

Product delivery date				
Payment date				
Delivery amount /tonnes/				

The seller shall be fully responsible for the accuracy of the entire information provided in this form. If there is any conflict between the advertisement form of Mongolian, English and Chinese, the Mongolian version shall be prevailed.

---oOo---

矿产品远期合同交易公告

1	卖方公司名称			
2	电子交易日期、交易时间			
3	矿产品种类			
4	质量指标、标准	种类	质量标准	
5	交易批量			
6	起拍价			
7	固定价格或指数价格			
8	拍卖时最低加价金额			
9	合同终止期限			
10	供货时间			
11	供货地点			
12	运输方式			
13	保证金			
14	保证金存入账户信息、币种			
15	其他信息			
16	交易所联系人电话			

产品供应时间表

产品供应期限				
付款期限				
供应量（吨）				

卖方对本表格中提供的信息真实性负全部责任。 如果蒙古文、英文、中文广告中的信息不一致，官方认为蒙古文广告为主的。

---oOo---

**УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ СПОТ ГЭРЭЭНИЙ
АРИЛЖААНЫ ЗАР**

1	Худалдагч этгээдийн нэр													
2	Арилжаа зохион байгуулагдах огноо, цаг													
3	Уул уурхайн бүтээгдэхүүний төрөл, ангилал													
4	Чанарын үзүүлэлт	<table><tr><th>Хэмжигдэхүүн</th><th>Чанарын үзүүлэлт</th></tr><tr><td></td><td></td></tr><tr><td></td><td></td></tr><tr><td></td><td></td></tr><tr><td></td><td></td></tr><tr><td></td><td></td></tr></table>	Хэмжигдэхүүн	Чанарын үзүүлэлт										
Хэмжигдэхүүн	Чанарын үзүүлэлт													
5	Багцын тоо, нийт хэмжээ													
6	Дуудах доод үнэ, валютын төрөл													
7	Дуудах үед үнэ өсгөх хамгийн бага дүн													
8	Бүтээгдэхүүнийг байршуулсан итгэмжлэгдсэн агуулах, терминал													
9	Хүргэлт хийх хугацаа, нөхцөл													
10	Бүтээгдэхүүн нийлүүлэх цэг													
11	Тээвэрлэлтийн төрөл													
12	Дэнчингийн хэмжээ													
13	Дэнчин байршуулах банкны дансны мэдээлэл, валютын төрөл													
14	Худалдан авагчид хүргэвэл зохих нэмэлт мэдээлэл													
15	Биржийн мэдээллийн ажилтантай холбоо барих утасны дугаар													

Энэхүү маягтад тусгасан мэдээллийн үнэн зөвийг худалдагч тал бүрэн хариуцна. Хэрэв Монгол, Англи, Хятад зар дахь мэдээлэл хоорондоо зөрөх тохиолдолд Монгол хэл дээрх зарыг зөв гэж үзнэ.

---oOo---

TRADING ADVERTISEMENT FOR SPOT CONTRACT OF MINING PRODUCTS

1	Seller's name		
2	Auction date and, time		
3	Type and classification of mining product		
4	Quality estimation	Measurements	Quality Index
5	Number of lots and, total weight		
6	Bid opening price and, currency		
7	minimum amount to increase the bid price during the auction /tick size/		
8	The accredited warehouse and terminal		
9	The delivery date and, type of incoterms		
10	point of delivery		
11	Transportation type		
12	Amount of collateral		
13	Bank account info for collateral and, its currency type		
14	Additional information for buyers		
15	contact information for further enquiries		

The seller shall be fully responsible for the accuracy of the entire information provided in this form. If there is any conflict between the advertisement form of Mongolian, English and Chinese, the Mongolian version shall be prevailed.

---oOo---

矿产品现货合同交易公告

1	卖方公司名称			
2	电子交易日期、交易时间			
3	矿产品种类			
4	质量指标, 标准	种类	质量标准	
5	交易批量			
6	起拍价			
7	拍卖时最低加价金额			
8	产品存放的授权仓库、园区			
9	供货时间			
10	供货地点			
11	运输方式			
12	保证金			
13	保证金存入账户信息, 币种			
14	其他信息			
15	交易所联系人电话			

卖方对本表格中提供的信息真实性负全部责任。如果蒙古文、英文、中文广告中的信息不一致, 官方认为蒙古文广告为主的。

---oOo---

ХУДАЛДАГЧААР БҮРТГҮҮЛЭХЭД БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

№	Баримт бичгийн төрөл	Хуудасны тоо
1	Монгол Улсын хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;	
2	Ашигт малтмал ашиглалтын хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар; (боловсруулах үйлдвэрийн хувьд ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээ)	
3	Техник, эдийн засгийн үндэслэл;	
4	Тухайн жилийн уулын ажлын төлөвлөгөө болон өмнөх жилийн уулын ажлын тайлан; (жич: боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаа эрхэлдэг Монгол Улсын хуулийн этгээдэд хамаарахгүй)	
5	Сүүлийн 1 жилийн аудитлагдсан санхүүгийн тайлан;	
6	Компанийн үйл ажиллагаа, бизнес төлөвлөгөөний танилцуулга;	
7	Эрх бүхий этгээдээр итгэмжлэгдсэн тээвэр, агуулах талбай, лабораторитой байгуулсан гэрээ;	
8	Брокероор оролцох тохиолдолд брокертой байгуулсан гэрээ;	
9	Биржээс шаардлагатай гэж үзсэн бусад.	

---oOo---

ХУДАЛДАН АВАГЧААР БҮРТГҮҮЛЭХЭД БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

№	Баримт бичгийн төрөл	Хуудасны тоо
1	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар (Монгол эсхүл Англи хэл дээрх баталгаат орчуулгын хамт)	
2	Харилцагч банкны дансны тодорхойлолт (Монгол эсхүл Англи хэл дээрх баталгаат орчуулгын хамт)	
3	Брокерын худалдан авагч бол брокертой байгуулсан гэрээ	
4	Биржээс шаардлагатай гэж үзсэн бусад	

---oOo---

/Энэ хавсралтыг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 48 дугаар тогтоолоор өөрчилсөн./

/Энэ хавсралтыг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн 35 дугаар тогтоолоор өөрчилсөн./

ИНДЕКСИЙН ХӨДӨЛГӨӨН ТООЦОХ АРГАЧЛАЛ

Индексийн хөдөлгөөнийг МХБ-ээс сар бүрийн 05-ны өдрийн дотор цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлнэ. Мэдээлэхдээ тухайн индексийн хөдөлгөөний үзүүлэлтийг өссөн тохиолдолд нэмэх (+) тэмдэг, буурсан тохиолдолд хасах (-) тэмдгээр тус тус тэмдэглэнэ. Хэрэв тухайн сарын 05-ны өдөр хагас сайн өдөр таарвал 04-нд, бүтэн сайн өдөр таарвал дараагийн өдөр буюу 06-ны өдөр, 3 ба түүнээс дээш хоногийн бүх нийтийн амралтын өдөр таарсан тохиолдолд тухайн сарын 05-ны өдөртэй аль ойрхон ажлын өдөр нийтэлнэ.

- Коксжих болон эрчим хүчний нүүрснээс бусад төрлийн нүүрсний гэрээний үнэд дээрх индексийн хөдөлгөөн хамаарахгүй
- Арилжааны системд хэлцэл хийгдсэн өдөр нь хуанлийн сарын 1-15-ны өдөр бол тухайн сар болон дараагийн сарын гэрээний үнийг тогтмол үнээр, 16-31-ний өдөр бол тухайн сар болон дараагийн 2 сарын гэрээний үнийг тогтмол үнээр тус тус тооцож, түүний дараагийн сараас эхлэн гэрээний үнийг индексийн хөдөлгөөнд суурилсан үнээр тооцож эхэлнэ.

Уул уурхайн бүтээгдэхүүний биржээр арилжаалагдсан коксжих нүүрс болон эрчим хүчний нүүрсний индексийн сагсны хөдөлгөөнийг тооцохдоо дор дурдсан дэс дарааллыг баримтална. Үүнд:

1. Индексүүдийн сарын дундаж утгыг тооцоолно;

Индекс бүрийн тухайн сарын арифметик дундаж олох замаар тооцоолно.

$$I_n(t) = \frac{\sum I_i}{d}$$

- $I_n(t)$ – n индексийн тухайн сарын дундаж үзүүлэлт
- I_i – тухайн өдрийн үзүүлэлт
- d – тухайн сарын нийт өдрийн тоо

2. Индексүүдийн сар бүрийн хөдөлгөөний коэффициентыг тодорхойлно.

Индекс бүрийн сарын дундаж үзүүлэлтийг өмнөх сартай харьцуулах замаар хөдөлгөөнийг /өөрчлөлтийн коэффициент/ тодорхойлно.

$$\Delta INDEX_n(t) = \frac{I_n(t) - I_n(t-1)}{I_n(t-1)} * 100\%$$

- $\Delta INDEX_n(t)$ – тухайн сарын n индексийн хөдөлгөөний коэффициент
- $I_n(t)$ – n индексийн тухайн сарын дундаж үзүүлэлт
- $I_n(t-1)$ – n индексийн өмнөх сарын дундаж үзүүлэлт

3. Индексийн сагсны өөрчлөлтийн хөдөлгөөний коэффициентыг тодорхойлно.

Тухайн сарын индексийн сагсны өөрчлөлтийн хөдөлгөөний коэффициентыг тодорхойлохдоо индекс бүрийн тухайн сарын үзүүлэлтийг сагсанд эзлэх хувийн жинд нь үржүүлж тооцоолно.

$$\Delta INDEX_{basket}(t) = w_1 * \Delta INDEX_1(t) + w_2 * \Delta INDEX_2(t) + w_3 * \Delta INDEX_3(t) + w_4 * \Delta INDEX_4(t) + w_5 * \Delta INDEX_5(t) + w_6 * \Delta INDEX_6(t)$$

- $\Delta INDEX_{basket}(t)$ - тухайн сарын сагсны индексийн хөдөлгөөний коэффициент
- w_n - n индексийн сагсанд эзлэх хувийн жин
- $INDEX_n(t)$ - тухайн сарын n индексийн хөдөлгөөний коэффициент

4. Индексийн сагсны хөдөлгөөний коэффициентыг ашиглан коксжих болон эрчим хүчний нүүрсний сар бүрийн үнийн хөдөлгөөнийг тодорхойлно.

Гэрээний эхний сард хэлцлийн үнийг индексийн хөдөлгөөний коэффициент ашиглан өөрчилнө.

$$P_t = P_0 * (1 + \Delta INDEX_{basket}(t))$$

- P_t - тухайн сарын үнэ
- P_0 - хэлцлийн үнэ
- $\Delta INDEX_{basket}(t)$ - тухайн сарын сагсны индексийн хөдөлгөөний коэффициент

Гэрээний 2 дох сараас өмнөх сарын буюу индексийн хөдөлгөөнийг тооцсон үнээс тухайн сарын индексийн хөдөлгөөний коэффициент ашиглан өөрчлөх зарчмаар үргэлжилнэ.

$$P_t = P_{t-1} * (1 + \Delta INDEX_{basket}(t))$$

- P_t - тухайн сарын үнэ
- P_{t-1} - хэлцлийн үнэ
- $\Delta INDEX_{basket}(t)$ - тухайн сарын сагсны индексийн хөдөлгөөний коэффициент

1. Коксжих нүүрсний индексийн хөдөлгөөн

Коксжих нүүрсний индексийн сагсны хөдөлгөөнийг тооцоход дараах индексүүд багтана:

№	Индекс нэршил	Эзлэх хувь	Индекс гаргадаг компани	Индекс гаргах хугацаа	Тайлбар
1	Ganqimaodu #4 Raw Coal	20%	БНХАУ-ын нүүрсний дата платформ SXCoal www.sxcoal.com	Өдөр тутам	БНХАУ-ын Ганцмод боомт дахь түүхий нүүрсний татвар орсон үнэ
2	CR Coking Coal Price Index-Composite	30%	БНХАУ-ын нүүрсний дата платформ SXCoal	Долоо хоног тутам, Даваа гараг	БНХАУ-ын дотоодын коксжих нүүрсний жигнэсэн дундаж үнэ
3	CR Washed Primary Coking price index - Production Place	25%	www.sxcoal.com	Долоо хоног тутам, Даваа гараг	БНХАУ-ын үйлдвэрлэлийн голлох 7 муж, дамжин өнгөрөх 2 цэг болон хэрэглээний 8

					үйлдвэрүүдийн баяжуулсан коксжих нүүрсний жигнэсэн дундаж үнэ
4	Shanxi Liulin 4# Raw Primary Coking	10%	БНХАУ-ын нүүрсний дата платформ SXCoal	Өдөр тутам	БНХАУ-ын хамгийн том нүүрсний бүс Шаньси мужийн 4 дүгээр давхаргын түүхий коксжих нүүрсний уурхайн амны дундаж үнэ.
5	Metal Bulletin Coking Coal Price Index, HCC CFR Jingtang	5%	Metal Bulletin www.fastmarkets.com	Өдөр тутам	Австрали, АНУ-ын 16-60 хоногийн дотор БНХАУ-ын Жинтан боомт хүргэж өгөх, "CFR Jingtang" нөхцөлтэй коксжих нүүрсний фьючерс үнэ.
6	Platts HCC 64 Mid Vol, CFR China	10%	S&P Global www.spglobal.com	Өдөр тутам	Хятадын Qingdao, Dalian, Qinhuangdao, Caofeidian, Jingtang зэрэг боомтуудад хүргэж өгөх нөхцөлтэй, Австралиас нийлүүлж буй коксжих нүүрсний биржийн спот үнэ

*Индексийн сагс ашигласан зарчим: БНХАУ-н дотоод зах зээлийг илэрхийлэх үнэ болон БНХАУ-н томоохон боомтууд дээр зарагдаж байгаа олон улсын нүүрсний үнийн индексүүд нь нүүрсний зах зээлийг бодит хэмжээнд илэрхийлнэ гэж үзсэн.

2. Эрчим хүчний нүүрсний индексийн хөдөлгөөн

Эрчим хүчний нүүрсний индексийн сагсны хөдөлгөөнийг тооцоход дараах индексүүд багтана:

№	Индекс нэршил	Эзлэх хувь	Индекс гаргадаг компани	Индекс гаргах хугацаа	Тайлбар
1	CCI 5500	25%	БНХАУ-ын нүүрсний дата	Өдөр тутам	БНХАУ-ын хойд боомт дахь гол жишиг

			платформ SXCoal		индекс
2	CECI 5500	25%	БНХАУ-ын нүүрсний дата платформ SXCoal	Өдөр тутам	БНХАУ-ын дотоодын эрчим хүчний нүүрсний үнэ
3	Ganqimadou 6000	20%	БНХАУ-ын нүүрсний дата платформ SXCoal	Өдөр тутам	БНХАУ-ын Ганцмод боомт дахь түүхий нүүрсний татвар орсон үнэ
4	Russian Coal, China-CFR	10%	БНХАУ-ын уул уурхайн бүтээгдэхүүн болон гангийн дата платформ MYSTEEL	Өдөр тутам	БНХАУ-д буух ОХУ- ын эрчим хүчний нүүрсний үнэ
5	New Castle Coal Australia, FOB	10%	БНХАУ-ын уул уурхайн бүтээгдэхүүн болон гангийн дата платформ MYSTEEL	Өдөр тутам	Австралийн НьюКастэл уурхайн эрчим хүчний нүүрсний үнэ
6	Kalimantan Island Coal Indonesia, FOB	10%	БНХАУ-ын уул уурхайн бүтээгдэхүүн болон гангийн дата платформ MYSTEEL	Өдөр тутам	Индонезийн эрчим хүчний нүүрсний үнэ

**Индексийн сагс ашигласан зарчим: БНХАУ-н дотоод зах зээлийг илэрхийлэх үнэ болон БНХАУ-н томоохон боомтууд дээр зарагдаж байгаа олон улсын нүүрсний үнийн индексүүд нь нүүрсний зах зээлийг бодит хэмжээнд илэрхийлнэ гэж үзсэн.*

---oOo---

ЗЭС, МОЛИБДЕНЫ БАЯЖМАЛЫН ДУУДАХ ДООД ҮНЭ БОЛОН ХӨВӨГЧ ҮНЭТЭЙ ГЭРЭЭНИЙ ТӨЛБӨРИЙН ҮНЭ ТООЦОХ АРГАЧЛАЛ

1. Зэс, молибдены баяжмалын дуудах доод үнийг тогтоох

- 1.1. Зэс, молибдены баяжмалын дуудах доод үнийг тооцоход зэсийн үнийг Лондонгийн Металлын Биржийн (LME Copper Grade A Settlement Daily Price), цагаан мөнгөний үнийг Лондонгийн Үнэт Металлын Зах Зээлийн Нийгэмлэгийн (LBMA Silver Daily Price), молибдены үнийг Лондонгийн Металлын Биржийн үнийн эх сурвалж болох S&P Global Platts Metals байгууллагын (Molybdenum Dealer Oxide Mean Daily price) өдөр тутам зарладаг үнийн мэдээлэлд үндэслэнэ. Зэс, молибдены баяжмалын дуудах доод үнэ Засгийн газрын холбогдох тогтоолын дагуу дээрх эх сурвалжаас зарлагдаж байгаа тухайн сарын үнээс багагүй байна.
- 1.2. Дуудах доод үнэ тооцох металлын үнийг (M_p) биржид арилжааны захиалгын хүсэлт ирүүлсэн өдрөөс өмнөх 7 болон 30 хоногийн дундаж үнийг тус тус тооцож, тэдгээрийн аль өндөр үнээр дараах аргачлалаар тогтооно.

$$M_p = (X_1 + X_2 + X_3 + \dots + X_n) / n$$

Үүнд:

- M_p – Дуудах доод үнэ тооцох металлын үнэ;
- X – Тухайн өдрийн металлын үнэ;
- n – Дундаж үнэ тооцоход ашигласан өдрийн тоо (7 эсхүл 30 хоног).

Дээрх томъёо нь зөвхөн баяжмал дахь цэвэр зэс, мөнгө, молибдены металлын үнийн тооцоолол бөгөөд үнийг үндэслэн худалдагч тухайн баяжмалын зэс, мөнгө, молибдены металлын агууламж дахь хувь болон хайлуулах, цэвэршүүлэх зардлыг захиалгын зартай хамт ирүүлсэн гэрээний төсөлд тусгаснаар тооцож, арилжааны дуудах доод үнийг тогтооно.

2. Зэс, молибдены баяжмалын хөвөгч үнэтэй гэрээний төлбөрийн үнэ тооцох

- 2.1. Зэс, молибдены баяжмалын гэрээний төлбөрийн үнэ тооцох металлын хөвөгч үнийг (M_f) зэсийн хувьд Лондонгийн Металлын Биржийн (LME Copper Grade A Settlement Monthly Average Price), цагаан мөнгөний хувьд Лондонгийн Үнэт Металлын Зах Зээлийн Нийгэмлэгийн (LBMA Silver Monthly Average Price), молибдены хувьд S&P Global Platts Metals байгууллагын (Molybdenum Dealer Oxide Mean Monthly Average price) ачилт хийсэн сарын дундаж үнийн мэдээлэлд үндэслэн тогтооно.
- 2.2. Энэхүү аргачлалын 2.1-д заасны дагуу тогтоосон металлын хөвөгч үнэд үндэслэн арилжааны гэрээгээр тохирсон нөхцөлийн дагуу тооцсон баяжмалын үнэ дээр арилжааны хэлцлийн үнэ болон дуудах доод үнийн зөрүүг нэмж, баяжмалын гэрээний төлбөрийн үнийг дараах байдлаар тогтооно.

$$P_f = P_c + (P_x - P_d)$$

Үүнд:

- P_f – Баяжмалын эцсийн үнэ;
- P_c – Металлын хөвөгч үнэд (M_f) үндэслэн тооцсон баяжмалын үнэ (баяжмалын үнийг 1.2-т заасны дагуу тооцно);
- P_x – Баяжмалын арилжааны хэлцлийн үнэ;
- P_d – Баяжмалын дуудах доод үнэ.

---oOo---



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 08 сарын 12 өдөр

Дугаар 26

Улаанбаатар хот

Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн
арилжааны төлбөр тооцооны журамд
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2, 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсгүүд, "Монголын хөрөнгийн бирж" хувьцаат компанийн Дүрмийн 5 дугаар зүйлийн 5.7.26 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 16 дугаар тогтоолын Хоёрдугаар хавсралтаар баталсан "Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны төлбөр тооцооны журам"-д дараах заалтыг нэмсүгэй. Үүнд:

1.1. Журмын 2 дугаар зүйлийн 2.6 дахь хэсэгт "Биржийн арилжаанд оролцогч талууд нь журамд заасан хугацаанд үйлчилгээний хөлс, арилжааны шимтгэлийг төлнө." гэж нэмэх;

1.2. Журмын 4 дүгээр 4.4 дэх хэсэгт "Худалдан авагч нь үйлчилгээний хөлсийг жил тутамд нэхэмжлэх хүлээж авснаас хойш ажлын 5 өдрийн дотор Биржийн дансанд шилжүүлнэ" гэж, 4.5 дахь хэсэгт "Хэрэв худалдан авагч журмын 4.4-т заасан үйлчилгээний хөлсийг хугацаанд нь шилжүүлээгүй тохиолдолд арилжааны системд хандах эрхийг хааж гэрээг цуцална." гэж тус тус нэмэх.

2. "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 16 дугаар тогтоолын Хоёрдугаар хавсралтаар баталсан "Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны төлбөр тооцооны журам"-д дараах нэмэлт, өөрчлөлтийг оруулсугай. Үүнд:

2.1. Журмын 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт "...уул уурхайн бүтээгдэхүүний биржийн спот, форвард гэрээний арилжааны төлбөр, тооцоог гүйцэтгэхтэй холбогдсон харилцааг зохицуулна." гэснийг "...уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны төлбөр, тооцоо, үйлчилгээний хөлстэй холбогдсон харилцааг зохицуулна." гэж өөрчлөх;

1526010086

2.2. Журмын 2 дугаар зүйлийн 2.5 дахь хэсэгт "...журмын Хавсралт 1-т заасан хэмжээгээр тодорхойлогдоно." гэснийг "...журмын Хавсралт 1-т заасан хэмжээгээр тодорхойлогдоно. Харин худалдан авагчийн жилийн үйлчилгээний хөлсний хэмжээ, ангиллыг Биржийн Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулсны үндсэн дээр Гүйцэтгэх захирлын тушаалаар тогтооно." гэж өөрчлөх;

2.3. Журмын 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэгт "...30-аас доошгүй минутын өмнө" гэснийг "...10-аас доошгүй минутын өмнө" гэж өөрчлөх;

2.4. Журмын 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт "...үйлчилгээний хөлс, жилийн үйлчилгээний хөлс, арилжааны шимтгэлийн нэхэмжлэхийг худалдагч, худалдан авагчид илгээнэ." гэснийг "...үйлчилгээний хөлс болон жилийн үйлчилгээний хөлс, арилжааны шимтгэлийн нэхэмжлэхийг худалдагч, худалдан авагчид илгээнэ." гэж өөрчлөх.

3. Энэ тогтоолын 1 болон 2 дахь хэсэгт заасан "Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны төлбөр тооцооны журам"-ын нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөх зөвшөөрөл авах асуудлыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу Санхүүгийн зохицуулах хороонд танилцуулж шийдвэрлүүлэхийг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Мөнхбат)-д даалгасугай.

4. Энэ тогтоолын 3 дахь хэсэгт заасны дагуу Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох шийдвэр гарсан өдрөөс эхлэн "Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны төлбөр тооцооны журам"-ын нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдүүлж, журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

5. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хороо (Ж.Золзаяа)-нд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ш.БАТ-ЭРДЭНЭ

Төлөөлөн удирдах зөвлөлийн
2025 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн
16 дугаар тогтоолын Хоёрдугаар хавсралт

**"МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ" ХУВЬЦААТ КОМПАНИЙН
УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БИРЖИЙН АРИЛЖААНЫ
ТӨЛБӨР ТООЦООНЫ ЖУРАМ**
/Шинэчилсэн найруулга/

*/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн 36 дугаар
тогтоолоор өөрчлөлт оруулсан./*

**УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БИРЖИЙН АРИЛЖААНЫ ТӨЛБӨР ТООЦООНЫ
ЖУРАМ**

НЭГ.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ	2
ХОЁР.АРИЛЖААНЫ ТӨЛБӨР, ТООЦОО.....	2
ГУРАВ. ХУДАЛДАН АВАГЧИЙН БАЙРШУУЛАХ ДЭНЧИН.....	2
ДӨРӨВ. АРИЛЖААНЫ ШИМТГЭЛ	4
ТАВ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА	5
<i>Хавсралт 1.</i>	6

**“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БИРЖИЙН АРИЛЖААНЫ ТӨЛБӨР ТООЦООНЫ
ЖУРАМ**

НЭГ.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1. Энэхүү Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны төлбөр тооцооны журам (цаашид “журам” гэх)-аар “Монголын хөрөнгийн бирж” ХК (цаашид “Бирж” гэх)-ийн уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны төлбөр, тооцоо, үйлчилгээний хөлстэй холбогдсон харилцааг зохицуулна.
/Энэ хэсгийг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн 36 дугаар тогтоолоор өөрчилсөн./
- 1.2. Уул уурхайн бүтээгдэхүүнд суурилсан фьючерс, опцион, санхүүгийн хэрэгслийн төлбөр, тооцооны үйл ажиллагааг энэ журмаар зохицуулахгүй.
- 1.3. Энэхүү журмаар зохицуулаагүй бусад харилцааг Иргэний хууль, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх) болон Биржээс баталсан бусад журам, заавраар зохицуулна.
- 1.4. Энэхүү журмыг Бирж, Биржийн арилжаанд оролцогчид, Биржийн зах зээлийн бусад оролцогчид дагаж мөрдөнө.
- 1.5. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн дэнчин, арилжааны шимтгэл, бүртгэх үйлчилгээний хөлстэй холбоотой төлбөр тооцоог Бирж өөрөө арилжааны банкаар дамжуулан гүйцэтгэнэ.

ХОЁР.АРИЛЖААНЫ ТӨЛБӨР, ТООЦОО

- 2.1. Биржийн арилжааны гэрээний үнийн дүн нь системд хийгдсэн хэлцлийн нийт үнийн дүнгээр, арилжааны валют нь зард тусгагдсан валютаар тодорхойлогдоно.
- 2.2. Энэхүү журмын Гуравдугаар бүлэгт заасны дагуу Худалдан авагч нь дэнчинг байршуулсны үндсэн дээр Биржийн арилжаанд оролцоно.
- 2.3. Гэрээний үнэ, дэнчин, арилжааны шимтгэлийг гадаад валютаар илэрхийлж болно.
- 2.4. Энэхүү журмын 2.3-т заасан валют (ам.доллар, юань)-ыг худалдагч тодорхойлно.
- 2.5. Биржийн бүртгэх үйлчилгээний хөлс, арилжааны шимтгэл нь журмын Хавсралт 1-т заасан хэмжээгээр тодорхойлогдоно. Харин худалдан авагчийн жилийн үйлчилгээний хөлсний хэмжээ, ангиллыг Биржийн Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулсны үндсэн дээр Гүйцэтгэх захирлын тушаалаар тогтооно.
/Энэ хэсгийг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн 36 дугаар тогтоолоор өөрчилсөн./
- 2.6. Биржийн арилжаанд оролцогч талууд нь журамд заасан хугацаанд үйлчилгээний хөлс, арилжааны шимтгэлийг төлнө.
/Энэ хэсгийг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн 36 дугаар тогтоолоор нэмсэн. /

ГУРАВ. ХУДАЛДАН АВАГЧИЙН БАЙРШУУЛАХ ДЭНЧИН

ХУДАЛДАН АВАГЧ ДЭНЧИН БАЙРШУУЛАХ

- 3.1. Худалдан авагчийн байршуулах дэнчингийн хэмжээ нь спот, форвард арилжааны хувьд уул уурхайн бүтээгдэхүүний доод үнээр илэрхийлсэн худалдах захиалгын нийт үнийн дүнгийн 10 хувь, брокероор дамжуулан арилжаанд оролцох тохиолдолд 5 хувьтай тэнцүү байна. Хэрэв Биржид бүртгэгдсэн худалдах захиалгад өөрчлөлт орж, дуудах доод үнэ өссөн тохиолдолд Худалдан авагч нь дэнчинг нэмж байршуулах шаардлагагүй
/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 48 дугаар тогтоолоор өөрчилсөн./
- 3.2. Худалдан авагч нь арилжаа эхлэхээс буюу бүртгэлийн үе эхлэхээс 10-аас доошгүй минутын өмнө энэ журмын 3.1-т тодорхойлсон дэнчинг Биржийн тусгайлан нээсэн дансанд байршуулсан байна. Тус хугацааг хэтрүүлсэн тохиолдолд арилжаанд оролцуулахгүй.
/Энэ хэсгийг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 08 дугаар сарын 12 -ны өдрийн 36 дугаар тогтоолоор өөрчилсөн./
- 3.3. Дэнчинг байршуулахдаа худалдан авагч эсхүл түүний брокер нь арилжааны банкин дахь өөрийн нэрийн данснаас шилжүүлэх бөгөөд гүйлгээний утга хэсэгт Биржийн арилжааны систем дэх компанийн бүртгэлийн дугаар, компанийн оноосон нэр, дэнчингийн зориулалтыг тусгасан байна.
- 3.4. Хэрэв худалдан авагч, түүний брокероос бусад гуравдагч этгээдийн данснаас дэнчинг шилжүүлсэн тохиолдолд дэнчинг байршуулсан гэж үзэхгүй. Тухайн мөнгийг шилжүүлсэн дансанд анх орж ирсэн валютаар, банкны гүйлгээний шимтгэлийг хассан дүнгээр буцаан шилжүүлнэ.

ХУДАЛДАН АВАГЧИЙН БАЙРШУУЛСАН ДЭНЧИНГЭЭР БАТАЛГААЖИХ ҮҮРЭГ

- 3.5. Худалдан авагчаар шалгарсан этгээдийн энэ журмын 3.1-т заасны дагуу Биржийн дансанд байршуулсан дэнчин нь биржийн арилжаатай холбоотой дараах үүргийг баталгаажуулна. Үүнд:
- 3.5.1. Биржийн арилжаанд оролцож худалдан авагчаар шалгарсан тохиолдолд Биржийн арилжааны шимтгэл төлөх үүрэг;
- 3.5.2. арилжааны гэрээг системд хийгдсэн хэлцлийн дагуу арилжаа дууссанаас хойш ажлын 5 өдрийн дотор бичгээр байгуулах үүрэг;
- 3.5.3. арилжааны гэрээний төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлөх үүрэг;
- 3.5.4. арилжааны гэрээнд заасан хугацаанд бүтээгдэхүүнийг хүлээн авах үүрэг.
- 3.6. Арилжаанд шалгарсан худалдан авагчийн дэнчинг арилжааны гэрээний үүргийг бүрэн гүйцэтгэж дуусах хүртэл хугацаанд битүүмжилнэ. Энэ тохиолдолд бусад арилжааны дэнчинд тооцуулах зорилгоор ашиглахгүй.
- 3.7. Бирж нь 3.5.1-т заасан үүргийг тэргүүн ээлжид хангуулж арилжааны шимтгэлийг дэнчингээс суутгана.

ДЭНЧИН БУЦААХ, БАТАЛГААЖУУЛАХ

- 3.8. Арилжаанд худалдан авагч үнийн санал ирүүлээгүй, худалдан авагч нь тухайн арилжаанд оролцоогүй эсхүл оролцсон боловч шалгараагүй тохиолдолд худалдан авагч нь дэнчин буцаан авах хүсэлтээ эрх бүхий этгээдийн гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулан, дэнчин шилжүүлсэн төлбөрийн баримтын хамт цахим системээр ирүүлнэ.
- 3.9. Бирж нь энэхүү журмын 3.8-д заасан шаардлага хангасан дэнчинг буцаан авах хүсэлтийг үндэслэн ажлын 5 өдрийн дотор, худалдан авагчийн дэнчинг шилжүүлсэн

- дансанд, анх орж ирсэн валютаар, банкны гүйлгээний шимтгэл хассан дүнгээр буцаан шилжүүлнэ.
- 3.10. Худалдан авагч дэнчин буцаах хүсэлтийг системээр ирүүлээгүй бол дэнчинг дараагийн арилжаанд оролцох зорилгоор Биржийн дансанд хэвээр үлдээсэнд тооцно.
- 3.11. Худалдан авагч нь 3.5.2 - 3.5.4-т заасан үүргээ хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр (хүндэтгэн үзэх шалтгаан гэдэгт гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл, төрийн эрх бүхий байгууллагын хориг, хязгаарлалтыг ойлгох ба энэ нь эрх бүхий байгууллагын гэрчилгээ, тодорхойлолтоор нотлогдсон байна) биелүүлээгүй бол Бирж дэнчинг худалдагчид ажлын 5 өдрийн дотор шилжүүлнэ.

АРИЛЖААНЫ ГЭРЭЭНИЙ ҮҮРЭГ БҮРЭН БИЕЛЭГДСЭНИЙ ДАРАА ДЭНЧИНГ ШИЛЖҮҮЛЭХ

- 3.12. Худалдагч нь талуудын гэрээ дүгнэсэн акт, гэрээний төлбөрийг бүрэн төлсөн баримт, дэнчин хүлээн авах нэхэмжлэхийг Биржид ирүүлнэ.
- 3.13. Худалдагч нь журмын 3.12-т заасан баримтуудыг ирүүлсний дараа Бирж нь дэнчинг ажлын 5 өдрийн дотор худалдагчийн дансанд шилжүүлнэ.
- 3.14. Хэрэв талууд гэрээг дүгнэсэн акт үйлдээгүй буюу талуудын хооронд арилжааны гэрээтэй холбоотой маргаан гарсан тохиолдолд тухайн маргааныг талууд эвийн журмаар шийдвэрлэх бөгөөд тохиролцоонд хүрч чадаагүй бол шүүх, арбитрын журмаар эцэслэн шийдвэрлэгдэх хүртэл хугацаанд Бирж дэнчинг аль нэг тал руу шилжүүлэхгүй.
- 3.15. Хэрэв Биржийн цахим арилжааны ялагч нь энэхүү журмын 3.5.2-т заасан үүргийг биелүүлээгүй, биелүүлэхээс зайлсхийсэн тохиолдолд энэхүү журмын 3.14 дэх заалт хамаарахгүй.
- 3.16. Худалдан авагч нь дэнчингийн үлдэгдлийг Биржтэй хагас жил, жил тутамд тулган баталгаажуулалт хийнэ.

ДӨРӨВ. АРИЛЖААНЫ ШИМТГЭЛ

- 4.1. Бирж нь бүртгэх үйлчилгээний хөлс болон жилийн үйлчилгээний хөлс, арилжааны шимтгэлийн нэхэмжлэхийг худалдагч, худалдан авагчид илгээнэ.
/Энэ хэсгийг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн 36 дугаар тогтоолоор өөрчилсөн./
- 4.2. Тухайн арилжаанд худалдан авагчаар шалгарсан этгээд нь энэхүү Журмын 4.1-т заасан нэхэмжлэх хүлээж авснаас хойш ажлын 3 өдрийн дотор Биржийн дансанд шилжүүлнэ.
- 4.3. Худалдагч нь бүртгэх үйлчилгээний хөлсийг худалдах захиалга бүртгэгдэн нэхэмжлэх хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор Биржийн дансанд шилжүүлнэ.
- 4.4. Худалдан авагч нь үйлчилгээний хөлсийг жил тутамд нэхэмжлэх хүлээж авснаас хойш ажлын 5 өдрийн дотор Биржийн дансанд шилжүүлнэ.
/Энэ хэсгийг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн 36 дугаар тогтоолоор нэмсэн./
- 4.5. Хэрэв худалдан авагч журмын 4.4-т заасан үйлчилгээний хөлсийг хугацаанд нь шилжүүлээгүй тохиолдолд арилжааны системд хандах эрхийг хааж гэрээг цуцална.
/Энэ хэсгийг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн 36 дугаар тогтоолоор нэмсэн./

Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны
төлбөр тооцооны журам

Хуудас 4

ТАВ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

- 5.1. Бирж нь зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулан худалдагч эсхүл худалдан авагчаас форвард гэрээний арилжаанд хязгаар тогтоох, дэнчингийн хэмжээг журамд зааснаар нэмэгдүүлэхийг шаардаж болно.
- 5.2. Худалдагч эсхүл худалдан авагч нь Журмын 5.1-т заасны дагуу нэмэлт дэнчинг цаг тухайд нь байршуулаагүй, эсхүл бусад зөрчил гаргасан тохиолдолд Бирж нь тухайн худалдан авагчийн арилжаанд оролцох эрхийг хязгаарлах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

---oOo---

“Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны төлбөр
тооцооны журам”-ын
Хавсралт 1.

**Уул уурхайн бүтээгдэхүүний арилжааны шимтгэл, үйлчилгээний хөлсний ерөнхий
нөхцөл**

Шимтгэл, үйлчилгээний хөлс төлөх этгээд	Зуучлагчгүй гэрээ	Зуучлагчтай гэрээ
Худалдагч талын бүртгэх үйлчилгээний хөлс төлөх хэмжээ	1 багц 100,000 төгрөг	
Худалдан авагч талын арилжааны шимтгэл төлөх хэмжээ	Тухайн хэлцлийн нийт үнийн дүнгийн 0.1 хувь	Тухайн хэлцлийн нийт үнийн дүнгийн 0.08 хувь

---o0o---



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 08 сарын 12 өдөр

Дугаар 37

Улаанбаатар хот

Нүүрсний спот, форвард гэрээний стандарт
тогтоох, мөрдүүлэх журамд нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг, "Монголын хөрөнгийн бирж" хувьцаат компанийн Дүрмийн 5 дугаар зүйлийн 5.7.26 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн 16 дугаар тогтоолын Гуравдугаар хавсралтаар баталсан "Нүүрсний спот, форвард гэрээний стандарт тогтоох, мөрдүүлэх журам"-д дараах нэмэлт, өөрчлөлтийг оруулсугай. Үүнд:

1.1. Журмын 2 дугаар зүйлийн 2.2.3 дахь заалтад "...форвард гэрээ 3 сар, 6 сар, 9 сар, 12 сарын хугацаатай байна." гэснийг "...форвард гэрээ 12 хүртэл сарын хугацаатай байна." гэж өөрчлөх;

1.2. Журмын 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэгт "...хэлцэл амжилттай хийгдсэнээс хойш ажлын 7 өдрийн дотор" гэснийг "...хэлцэл амжилттай хийгдсэнээс хойш ажлын 10 өдрийн дотор" гэж, 4.3 дахь хэсэгт "...хэлцэл хийгдсэнээс хойш ажлын 7 өдрийн дотор урьдчилгаа төлбөр болох гэрээний нийт үнийн дүнгийн" гэснийг "...хэлцэл хийгдсэнээс хойш ажлын 10 өдрийн дотор урьдчилгаа төлбөр болох хэлцлийн нийт үнийн дүнгийн" гэж тус тус өөрчлөх;

1.3. Журмын 7 дугаар зүйлийн 7.17 дахь хэсэгт "...хяналт тавих зорилгоор нийт шинжилгээний дээжийн 10-аас доошгүй хувьд Геологийн судалгаа, шинжилгээний төв шинжилгээ хийж дүгнэлт гаргана." гэснийг "...хяналт тавих зорилгоор шаардлагатай тохиолдолд нийт шинжилгээний дээжийн 10-аас доошгүй хувьд Геологийн судалгаа, шинжилгээний төв шинжилгээ хийж дүгнэлт гаргана." гэж өөрчлөх.

2. Энэ тогтоолын 1 дэх хэсэгт заасан "Нүүрсний спот, форвард гэрээний стандарт тогтоох, мөрдүүлэх журам"-ын нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөх зөвшөөрөл авах асуудлыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу Санхүүгийн зохицуулах хороонд танилцуулж шийдвэрлүүлэхийг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Мөнхбат)-д даалгасугай.

1526010088

3. Энэ тогтоолын 2 дахь хэсэгт заасны дагуу Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох шийдвэр гарсан өдрөөс эхлэн “Нүүрсний спот, форвард гэрээний стандарт тогтоох, мөрдүүлэх журам”-ын нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдүүлж, журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хороо (Ж.Золзаяа)-нд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ш.БАТ-ЭРДЭНЭ

Төлөөлөн удирдах зөвлөлийн
2025 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн
16 дугаар тогтоолын Гуравдугаар хавсралт

**"МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ" ХУВЬЦААТ КОМПАНИЙН
НҮҮРСНИЙ СПОТ, ФОРВАРД ГЭРЭЭНИЙ СТАНДАРТ ТОГТООХ,
МӨРДҮҮЛЭХ ЖУРАМ**

/Шинэчилсэн найруулга/

*/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 08 дугаар сарын 12 -ны өдрийн 37 дугаар
тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулсан./*

НҮҮРСНИЙ СПОТ, ФОРВАРД ГЭРЭЭНИЙ СТАНДАРТ ТОГТООХ, МӨРДҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг.Ерөнхий үндэслэл.....	2
Хоёр.Арилжааны гэрээнд тавигдах шаардлага.....	2
Гурав. Арилжааны гэрээг байгуулсанд тооцох, биржид бүртгүүлэх	3
Дөрөв. Арилжааны гэрээний төлбөрийг гүйцэтгэх.....	3
Тав. Арилжааны гэрээний хэрэгжилт, түүнд тавих хяналт.....	3
Зургаа. Арилжааны гэрээг дуусгавар болгох, түүний үр дагавар	4
Долоо.Тээвэрлэлт, хадгалалт, чанарын хяналт.....	4
<i>Тээвэр логистик</i>	4
<i>Агуулахын баримт, хадгалалт</i>	5
<i>Чанарын хяналт</i>	5
Найм. Бусад.....	6
“Нүүрсний спот, форвард гэрээний стандарт тогтоох, мөрдүүлэх журам”-ын Хавсралт 1..7	
“Нүүрсний спот, форвард гэрээний стандарт тогтоох, мөрдүүлэх журам”-ын Хавсралт 2 11	
“Нүүрсний спот, форвард гэрээний стандарт тогтоох, мөрдүүлэх журам”-ын Хавсралт 3 15	

**НҮҮРСНИЙ СПОТ, ФОРВАРД ГЭРЭЭНИЙ СТАНДАРТЫГ ТОГТООХ,
МӨРДҮҮЛЭХ ЖУРАМ**

Нэг.Ерөнхий үндэслэл

- 1.1. Энэхүү журмаар “Монголын хөрөнгийн бирж” ХК (цаашид “Бирж” гэх)-иар арилжаалсан нүүрсний спот, форвард арилжааны гэрээний стандартыг тогтоох, хэрэгжилтэд хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулна.
- 1.2. Энэхүү журамд заасан үйл ажиллагаа нь Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх) болон Биржээс баталсан журам, заавар, түүнд нийцүүлэн гаргасан бусад шийдвэрийн хүрээнд хэрэгжинэ.
- 1.3. Энэхүү журмыг Биржийн арилжаанд оролцогчид, Биржийн зах зээлийн бусад оролцогчид дагаж мөрдөнө.

Хоёр.Арилжааны гэрээнд тавигдах шаардлага

- 2.1. Гэрээгээр арилжаалах нүүрсний 1 багц нь 6,400 тонн байна.
- 2.2. Арилжааны гэрээ нь спот, тогтмол үнэтэй форвард гэрээ, индексэд суурилсан үнэтэй форвард гэрээний төрөлтэй байна.
 - 2.2.1. Спот гэрээний хугацаа 30 буюу түүнээс доош хоногийн хугацаатай байна.
 - 2.2.2. Тогтмол үнэтэй форвард гэрээ 12 хүртэл сарын хугацаатай байна.
 - 2.2.3. Индексэд суурилсан үнэтэй форвард гэрээ 12 хүртэл сарын хугацаатай байна.
/Энэ заалтыг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн 37 дугаар тогтоолоор өөрчилсөн./
- 2.3. Худалдагч, худалдан авагч нь арилжааны гэрээг энэхүү журмын Хавсралтаар баталсан стандарт нөхцөлөөр байгуулна.
- 2.4. Хэрэв арилжааны гэрээний үнэ нь индексэд суурилсан нөхцөлөөр арилжааны зард тусгагдсан бол гэрээний хүчинтэй хугацаанд нүүрсний зах зээлийн үнэ нь хэлцлийн үнээс өөрчлөгдөх тохиолдолд Биржийн “Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны журам”-ын Хавсралт 6-т заасан аргачлалын дагуу тооцно.
- 2.5. Нүүрсний шинж чанар, онцлогоос шалтгаалж нийлүүлэлтийн явцад чанар өөрчлөгдөх эрсдэлтэй гэж үзэж худалдах арилжааны зард чанарын зөрүүнд тооцох үнийн нэмэгдэл, бууралтыг тооцох аргачлал, хувь хэмжээг заасан бол талууд тус нэмэгдэл, бууралтыг гэрээнд тусгана.
- 2.6. Арилжааны гэрээ болон түүнтэй холбоотой бусад харилцаанд зөвхөн Монгол Улсын хуулийг хэрэглэнэ.

Гурав. Арилжааны гэрээг байгуулсанд тооцох, биржид бүртгүүлэх

- 3.1. Уул уурхайн бүтээгдэхүүний цахим арилжаа амжилттай зохион байгуулагдаж, хэлцэл хийгдсэнээр арилжааны гэрээ байгуулагдсанд тооцож, Биржид бүртгэгдэнэ.
- 3.2. Арилжааны гэрээг байгуулахдаа гэрээний хугацаа эхлэх өдрийг арилжааны системд хэлцэл амжилттай хийгдсэн өдрөөр тусгана.
- 3.3. Талууд арилжааны гэрээг хэлцэл биелснээс хойш ажлын 5 өдрийн дотор байгуулан Биржид ирүүлэх үүрэгтэй. Гэрээг байгуулж ирүүлээгүй нь гэрээний үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.
- 3.4. Талууд арилжааны гэрээг байгуулахдаа системд хийгдсэн хэлцлийн дагуу энэхүү журмын Хавсралтад заасан стандарт нөхцөлөөр байгуулна.
- 3.5. Талуудын байгуулсан арилжааны гэрээ болон түүний нэмэлт гэрээг тухай бүр Биржид бүртгүүлнэ.
- 3.6. Худалдан авагч нь арилжааны зар болон энэхүү журмын хавсралтаар баталсан гэрээний стандарт нөхцөлтэй урьдчилан танилцаагүй, танилцах боломжгүй байсан нь арилжааны гэрээг нэг талын санаачилгаар цуцлах, дуусгавар болгох, тухайн гэрээний үүрэг хариуцлагаас чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.

Дөрөв. Арилжааны гэрээний төлбөрийг гүйцэтгэх

- 4.1. Спот гэрээний нийт төлбөрийг дэнчин хассан дүнгээр худалдан авагч нь хэлцэл амжилттай хийгдсэнээс хойш ажлын 7 өдрийн дотор худалдагчийн дансанд шилжүүлнэ.
- 4.2. Тогтмол үнэтэй форвард гэрээний төлбөрийг дэнчин хассан дүнгээр худалдагчаас ирүүлсэн нэхэмжлэхийн дагуу хэлцэл амжилттай хийгдсэнээс хойш ажлын 10 өдрийн дотор шилжүүлнэ.
/Энэ хэсгийг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 08 дугаар сарын 12 -ны өдрийн 37 дугаар тогтоолоор өөрчилсөн./
- 4.3. Индексэд суурилсан үнэтэй форвард гэрээний төлбөрийг хэлцэл хийгдсэнээс хойш ажлын 10 өдрийн дотор урьдчилгаа төлбөр болох хэлцлийн нийт үнийн дүнгийн 25%-ийг худалдагчийн дансанд шилжүүлнэ.
/Энэ хэсгийг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн 37 дугаар тогтоолоор өөрчилсөн./
- 4.4. Журмын 4.3-т заасан гэрээний үлдэгдэл төлбөрийг нийлүүлэлттэй уялдуулан, нийлүүлэлт хийгдэхээс ажлын 5 өдрийн өмнө тухай бүр шилжүүлэх эсхүл банкны аккредитиваар гүйцэтгэж болно.

Тав. Арилжааны гэрээний хэрэгжилт, түүнд тавих хяналт

- 5.1. Худалдагч эсхүл түүний брокер нь спот, форвард гэрээний хэрэгжилтийн талаарх тайланг Биржид сар бүрийн 10-ны өдөр шинэчлэн ирүүлнэ.
- 5.2. Энэхүү журмын 5.1-т заасан тайланд дараах мэдээллийг тусгасан байна.Үүнд:
 - 5.2.1. бүтээгдэхүүний төлбөр төлсөн баримт;
 - 5.2.2. нийлүүлсэн бүтээгдэхүүний тоо хэмжээ;
 - 5.2.3. тээвэрлэлтийн мэдээлэл;

- 5.3. Бирж нь арилжааны гэрээний хэрэгжилтэд хяналт тавих зорилгоор худалдагч эсхүл түүний брокероос нэмэлт мэдээлэл шаардаж болно.
- 5.4. Арилжааны гэрээний хэрэгжилтийг хангахтай холбоотойгоор бүтээгдэхүүнийг хадгалах, тээвэрлэх, шинжилгээ хийлгэхдээ зөвхөн Биржийн итгэмжлэгдсэн этгээдээр гүйцэтгүүлнэ.

Зургаа. Арилжааны гэрээг дуусгавар болгох, түүний үр дагавар

- 6.1. Арилжааны гэрээ дараах тохиолдолд дуусгавар болно. Үүнд:
 - 6.1.1. талууд гэрээг хугацаанаас нь өмнө дуусгавар болгохоор харилцан тохиролцсон
 - 6.1.2. талууд арилжааны гэрээний үүргийг бүрэн биелүүлсэн;
 - 6.1.3. холбогдох хууль тогтоомж болон гэрээнд заасны дагуу гэрээ дуусгавар болох үндэслэл бий болсон.
- 6.2. Гэрээг дуусгавар болгоход баримтлах нөхцөл
 - 6.2.1. Худалдагч, худалдан авагч тал нь гэрээг хугацаанаас нь өмнө дуусгавар болгохоор харилцан тохиролцсон бол гэрээг дуусгавар болж байгаа үндэслэл, шалтгаан болон дэнчинг гэрээний аль талд шилжүүлэх тухай акт үйлдэж, тус актыг Биржид ирүүлнэ
 - 6.2.2. Талууд арилжааны гэрээний үүргийг бүрэн биелүүлсэн бол Биржийн "Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны төлбөр тооцооны журам"-д заасан баримт бичгийг Биржид ирүүлнэ.
- 6.3. Гэрээг дуусгавар болгосон, хүчингүйд тооцсоны үр дагавар
 - 6.3.1. Гэрээг дуусгавар болгосон тохиолдолд арилжааны дэнчинтэй холбоотой харилцааг Биржийн "Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны төлбөр тооцооны журам"-аар зохицуулна.
- 6.4. Арилжааны системд хийгдсэн арилжааны гэрээг цуцлах, дуусгавар болгохтой холбоотой харилцаанд 6.1, 6.2, 6.3-т заасан зохицуулалт нэгэн адил хэрэглэгдэнэ.

Долоо.Тээвэрлэлт, хадгалалт, чанарын хяналт

Тээвэр логистик

- 7.1. Бүтээгдэхүүнийг итгэмжлэгдсэн агуулах, терминалаас нийлүүлэх цэгт хүргэх ажиллагааг худалдагчтай гэрээ байгуулсан Биржийн итгэмжлэгдсэн тээвэр логистикийн үйл ажиллагаа эрхлэгч гүйцэтгэнэ.
- 7.2. Худалдагч нь хүргэлт хийх тээврийн хэрэгслийн дугаар, хүргэлтийн маршрут, бүтээгдэхүүн, тоо хэмжээ, очих хугацааны талаар мэдээллийг итгэмжлэгдсэн агуулах, терминалд бүтээгдэхүүнийг хүргэхээс 3 хоногийн өмнө мэдэгдэнэ.
- 7.3. Худалдан авагчтай байгуулсан гэрээнд өөрөөр заагаагүй бол Худалдагч нь бүтээгдэхүүний гэрээнд заасан газарт хүргэх хүртэл хугацааны тээвэрлэлтийн эрсдэлийг хариуцна.
- 7.4. Тээвэр логистикийн үйл ажиллагаа эрхлэгч нь тээвэрлэлтийн гэрээ байгуулсан этгээдийн өмнө хариуцлага хүлээнэ.
- 7.5. Худалдан авагч Биржийн итгэмжлэгдсэн тээвэр логистикийн үйл ажиллагаа эрхлэгчийг ашиглахгүйгээр бүтээгдэхүүнийг хүлээн авах бол ачилт хийгдсэнээр хүргэлтийн үйл ажиллагаа дууссан гэж үзнэ.

Агуулахын баримт, хадгалалт

- 7.6. Итгэмжлэгдсэн агуулах, терминал нь бүтээгдэхүүнийг хүлээн авах, ачилт хийж дуусах хүртэл чанар, тоо хэмжээ, аюулгүй байдлыг хариуцна.
- 7.7. Итгэмжлэгдсэн агуулах, терминал нь бүтээгдэхүүнийг хадгалахдаа үндэсний холбогдох стандартад заасан хадгалалтын нөхцөлийг баримтлахаас гадна дараах нөхцөлийг бүрдүүлж ажиллана:
- 7.7.1. камерын хяналтын системийг бүрдүүлсэн байх;
- 7.7.2. бүтээгдэхүүний овоолгын нэршлийн самбартай байх.
- 7.8. Итгэмжлэгдсэн агуулах, терминал нь Биржээр арилжих, арилжсан бүтээгдэхүүнийг хүлээн авч "Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны журам"-ын Хавсралт 3 /цаашид "агуулахын баримт" гэх/-г үйлдэн Биржид ирүүлнэ.
- 7.9. Итгэмжлэгдсэн агуулах, терминал нь итгэмжлэгдсэн лабораториор дээж авхуулах, шинжилгээ хийлгэх үйл ажиллагаанд хамтарч ажиллана. Худалдагч, эсхүл брокер нь шинжилгээний дүнг Биржид ирүүлнэ.
- 7.10. Худалдагч нь худалдан авагчтай байгуулсан гэрээний дагуу бүтээгдэхүүний төлбөрийг хүлээн авсан тухай баримтыг Биржид ирүүлснээр Бирж бүтээгдэхүүнийг хүлээн авах мэдэгдлийг худалдан авагч, эсхүл брокер болон итгэмжлэгдсэн агуулах, терминалд хүргүүлнэ.
- 7.11. Худалдагч нь агуулах, терминалаас ачилт хийхээс ажлын 3 хоногийн өмнө энэ талаар итгэмжлэгдсэн агуулах, терминалд мэдэгдэж, бүтээгдэхүүнийг хүлээн авах этгээдийн биеийн байцаалт, чингэлэг, тээврийн хэрэгсэл болон бүтээгдэхүүн хүлээн авах мэдэгдлийн талаар мэдээллийг урьдчилан итгэмжлэгдсэн агуулах, терминалд хүргүүлнэ.
- 7.12. Итгэмжлэгдсэн агуулах, терминал нь гэрээний дагуу нийлүүлэх бүтээгдэхүүний ачилтыг хийн худалдан авагчид хүлээлгэн өгч акт үйлдэн, итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүнгийн хамт Биржид ирүүлнэ.
- 7.13. Спот гэрээгээр арилжаалах бүтээгдэхүүнийг арилжаа зохион байгуулагдах өдрөөс ажлын 5-аас доошгүй өдрийн өмнө итгэмжлэгдсэн агуулах, терминалд байршуулж, бүртгэсэн байна.
- 7.14. Итгэмжлэгдсэн агуулах, терминал нь бүтээгдэхүүнийг хүлээн авах, хүлээлгэн өгөх бүртгэлийг хөтлөх бөгөөд Бирж нь хяналт, шалгалтын зорилгоор бүртгэл, агуулахын баримтыг тухай бүр шалгах эрхтэй байна.
- 7.15. Агуулахын баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн итгэмжлэгдсэн агуулах, терминал хариуцна.

Чанарын хяналт

- 7.16. Худалдагч нь итгэмжлэгдсэн агуулах, терминалд байршуулсан бүтээгдэхүүнд чанарын шинжилгээ хийлгэх гэрээг Биржийн итгэмжлэгдсэн лабораторитой байгуулна.
- 7.17. Итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээнд төрийн байгууллагын зүгээс хяналт тавих зорилгоор шаардлагатай тохиолдолд нийт шинжилгээний дээжийн 10-аас доошгүй хувьд Геологийн судалгаа, шинжилгээний төв шинжилгээ хийж дүгнэлт гаргана.
/Энэ хэсгийг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн 37 дугаар тогтоолоор өөрчилсөн./
- 7.18. Итгэмжлэгдсэн лаборатори нь итгэмжлэгдсэн агуулах, терминалд байршсан бүтээгдэхүүнээс Монгол Улсын холбогдох стандартад заасан аргачлалын дагуу дээж авч шинжилгээ хийнэ.
- 7.19. Итгэмжлэгдсэн агуулах, терминал нь бүтээгдэхүүнийг агуулах, терминалд хүлээн авах

- болон агуулахаас ачилт хийх үеийн жинг үнэн зөв тооцож, баталгаажуулна.
- 7.20. Итгэмжлэгдсэн лаборатори нь бүтээгдэхүүний чанарын шинжилгээг хийж дууссаны дараа шинжилгээний үр дүнгийн хуудасны эх хувийг агуулах, терминалд, хуулбар хувийг Бирж болон худалдагчид хүргүүлнэ.
- 7.21. Итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний үр дүнгийн хуудаст дээжийн мэдээлэл, сорилт, шинжилгээг гүйцэтгэсэн стандарт, шинжилгээ хийсэн үзүүлэлт, зөвшөөрөгдөх хэмжээ, хэмжих нэгж, үр дүнг тусгасан байна.
- 7.22. Итгэмжлэгдсэн агуулах, терминал нь бүтээгдэхүүнийг агуулах, терминалаас ачих үед итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний үр дүнгийн хуудсыг худалдан авагчид хүлээлгэн өгнө.
- 7.23. Чанарын маргаанаас шалтгаалан агуулах, терминалаас ачилт хийгдээгүй тохиолдолд худалдан авагч нь итгэмжлэгдсэн агуулах, терминалд мэдэгдэн ачилтыг түр хойшлуулж болно. Энэ тохиолдолд худалдан авагч нь Биржээс бүтээгдэхүүн хүлээн авах мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор давтан шинжилгээ хийлгэх хүсэлтийг Биржид гаргана. Давтан шинжилгээ хийлгэх хүсэлтэд агуулах, терминалын нэр, бүтээгдэхүүний байршил, тоо хэмжээ, чанарын үзүүлэлт, холбоо барих хаяг болон шаардлагатай бусад мэдээллийг тусгаж, албан ёсны тамга, тэмдэг дарж баталгаажуулсан байна. Давтан шинжилгээг худалдагч, худалдан авагчийн тохиролцож сонгосон Биржийн итгэмжилсэн шинжилгээний лаборатори гүйцэтгэх бөгөөд давтан шинжилгээний үр дүнгээс хамаарч төлбөрийг худалдан авагч, эсхүл худалдагч хариуцна.
- 7.24. Худалдан авагч нь заасан хугацаанд тогтоосон журмын дагуу давтан шинжилгээ хийлгэх хүсэлт гаргаагүй тохиолдолд агуулах, терминалаас ачсан бүтээгдэхүүний чанарыг хүлээн зөвшөөрсөн гэж үзнэ.
- 7.25. Давтан шинжилгээний дүн болон анхдагч шинжилгээний үр дүн нь Монгол Улсын Стандарт, хэмжил зүйн газраас баталсан холбогдох стандартаар тогтоосон стандарт хазайлтын хүрээнд багтах тохиолдолд шинжилгээний чанар хангалт шаардлага хангасан гэж үзнэ.
- 7.26. Давтан шинжилгээний дүн болон анхдагч шинжилгээний үр дүн нь зөрүүтэй бөгөөд уг зөрүү нь стандарт хазайлтын хүрээнээс илүү гарсан тохиолдолд худалдагч болон худалдан авагч талуудын хооронд байгуулсан экспортын гэрээ буюу худалдах, худалдан авах гэрээгээр зохицуулна.

Найм. Бусад

- 8.1. Арилжааны гэрээ болон энэ журамд заасан үүргийг талууд зөрчсөн тохиолдолд холбогдох хууль, журамд заасны дагуу хариуцлага ногдуулна.
- 8.2. Худалдагч, худалдан авагч талууд нь энэхүү журмын Хавсралтаар баталсан стандарт нөхцөлийг арилжааны гэрээнд заавал тусгах бөгөөд бусад нөхцөлийг холбогдох хууль, журамд нийцүүлэн харилцан тохиролцож болно.
- 8.3. Энэхүү журмын хэрэгжилтэд Бирж хяналт тавина.

---oOo---

“Нүүрсний спот, форвард гэрээний стандарт
тогтоох, мөрдүүлэх журам”-ын Хавсралт 1

**БИРЖЭЭР АРИЛЖСАН
НҮҮРСНИЙ ЭКСПОРТЫН СПОТ ГЭРЭЭ**

“.....”ХК/ХХК/ТӨҮГ

“.....”ХК/ХХК/ТӨҮГ

Гэрээний дугаар

[2025]

**БИРЖЭЭР АРИЛЖСАН
НҮҮРСНИЙ ЭКСПОРТЫН СПОТ ГЭРЭЭ
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ОГНОО**
[20-.... -....]

ХУДАЛДАГЧ	"....." ХК/ХХК/ТӨҮГ
Хаяг:	
Утас:	
Цахим хаяг:	

ХУДАЛДАН АВАГЧ	
Хаяг:	
Утас:	
Цахим хаяг:	
Бусад холбоо барих мэдээлэл	

УДИРТГАЛ ХЭСЭГ

Энэхүү Биржээр арилжсан нүүрсний экспортын гэрээ (цаашид “Гэрээ” гэх)-г нэг талаас “.....” ХК/ХХК/ТӨҮГ (цаашид “Худалдагч” гэх), нөгөө талаас (цаашид “Худалдан авагч” гэх) (цаашид хамтад нь “Талууд” гэх) нар нь 202... оны ... дугаар сарын ...-ны өдөр “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн цахим арилжааны системд амжилттай хийгдсэн ... багц буюу нийт ... тонн/нүүрсний төрөл, ангилал/ (цаашид “Нүүрс” гэх)-ийг худалдах, худалдан авах ... дугаар хэлцлийн дагуу эрх тэгш, нээлттэй байх зарчмын үндсэн дээр дор дурдсан нөхцөлийг харилцан тохиролцож байгуулав. Үүнд:

НЭГ. ГЭРЭЭНИЙ ГОЛ НӨХЦӨЛ	
Нэг.Гэрээний хугацаа	1.1.Энэхүү Гэрээний хугацаа нь системд хэлцэл амжилттай хийгдэж, Талууд харилцан тохиролцсон хуваарийн дагуу Нүүрсийг нийлүүлж дуусах хүртэл хоногийн хугацаатай байна. 1.2.Гэрээний дуусгавар болох хугацаа-ны өдөр хүртэл байна.
Хоёр.Нүүрсний гарал үүсэл	2.1. Гарал үүсэл: Энэхүү Гэрээний дагуу нийлүүлэх Нүүрсийг Монгол улс, аймаг, суманд байрлах уурхайгаас (цаашид “Уурхай” гэх) олборлосон байна.
Гурав.Нийлүүлэх нүүрсний хэмжээ, хуваарь нүүрс нийлүүлэх цэг	3.1. Нийлүүлэх нүүрсний хэмжээ: Нэг багцын хэмжээ нь 6400 тонн байх бөгөөд энэхүү гэрээгээр багц нүүрс буюу нийт ... тонн Нүүрсийг нийлүүлнэ. 3.2. Худалдагч нь Нүүрсийг арилжааны зард тусгасны дагуу 20... оны ... сарын ...-ны өдрийн дотор нийлүүлнэ. 3.3. Нүүрс нийлүүлэх цэг: Нүүрсийг DAP (байршил) (Инкотермс-2020)-ийн нөхцөлөөр нийлүүлнэ. 3.4. Нүүрс хүлээн авах: Худалдан авагч нь энэ гэрээний дагуу

	чингэлэг бэлдэх, нийлүүлэх нүүрсийг Нүүрс нийлүүлэх цэгээс 24 цагийн дотор хүлээн авах, контейнер /нүүрс/ буулгалтыг гүйцэтгэх үүрэгтэй ба ирсэн нүүрсийг цаг тухайд нь хүлээн аваагүйгээс үүдэн гарах аливаа хохирол түүний үр дагавар, Худалдагчид учирсан зардал агуулах, терминалын төлбөрийг Худалдан авагч хариуцна.
Дөрөв.Нүүрсний чанар	4.1. Гэрээний дагуу нийлүүлэх Нүүрс нь Монгол Улсын MNS 6457:2023 “Нүүрс, нүүрсэн бүтээгдэхүүний ангилал” стандартад заасан төрөл, ангилал, чанарын үзүүлэлтэд нийцсэн байна. Худалдагчийн нийлүүлэх нүүрс нь дараах чанарын шаардлага хангасан байна. /Зард тусгагдсан чанарын үзүүлэлтүүдийг тусгана уу./ Үнслэг (хуурай,%) Дэгдэмхий бодис (үнсгүй хуурай,%) Хүхэр (хуурай, %) Нийт чийглэг (хүлээн авах үеийн төлөв,%) 4.2. Энэхүү Гэрээгээр нийлүүлэх Нүүрсний чанарыг Худалдагчийн дахь гаалийн хяналтын талбайгаас авсан нүүрсний дээжийг итгэмжлэгдсэн лаборатори (“итгэмжлэгдсэн лаборатори” гэж Гаалийн төв лаборатори эсхүл Биржийн итгэмжлэгдсэн бусад лабораторид хийгдсэн нүүрсний чанарын шинжилгээгээр тодорхойлно. 4.3. Талуудын хооронд нийлүүлсэн нүүрсний чанарын талаар маргаан үүсвэл гуравдагч дээжийг авч, нүүрсний чанарын шинжилгээг талуудын сонгосон, магадлан итгэмжлэгдсэн хөндлөнгийн лабораторид хийлгэх бөгөөд шинжилгээний үр дүнгээр маргааныг эцэслэн шийдвэрлэнэ. Хөндлөнгийн лабораторид гуравдагч дээжийн чанарыг шинжлүүлэхтэй холбогдон гарах зардлыг талууд тэнцүү хэмжээгээр хамтран хариуцна.
Тав.Үнэ болон төлбөрийн нөхцөл	5.1. Үнэ: Нүүрсний үнэ нь Биржийн арилжааны систем дээр хийгдсэн 202... оны ... дугаар сарын ...-ны өдрийн ... тоот хэлцлийн дагуу ____ юань/ам.доллар (____) байна. Энэхүү Нүүрсний үнэд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу төлөх НӨАТ ороогүй болно. 5.2.Төлбөр төлөх нөхцөл: Худалдан авагч нь гэрээ байгуулснаас хойш ажлын 2 өдрийн дотор Худалдагчийн ирүүлсэн нэхэмжлэхийн дагуу төлбөрийг 100 (дэнчин хассан дүнгээр) хувь шилжүүлнэ. Дээрх гэрээний төлбөрийг Худалдагчийн банкин дахь нэрийн дансанд шилжүүлнэ. Худалдагчийн дансны мэдээлэл: Хүлээн авагч: ХХК/ХК/ТӨҮГ Хүлээн авагчийн хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, дүүрэг, байр,..... давхар Хүлээн авагчийн банк: банк Банкны хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, дүүрэг,байр Swift код: Дансны дугаар:

Зургаа. Хариуцлага	6.1. Худалдагч нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээнд заасан хугацаанд зохих бүтээгдэхүүнийг нийлүүлэх цэгт бүрэн хүргээгүй тохиолдолд талуудын гэрээнд өөрөөр заагаагүй бол хугацаа хэтэрсэн хоног тутамд нийлүүлэх цэгт хүргээгүй бүтээгдэхүүний үнийн дүнгийн 0.1%-тай тэнцэх алдангийг худалдан авагчид төлнө. 6.2. Худалдан авагч нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээнд заасан хугацаанд худалдан авсан бүтээгдэхүүнээ бүтээгдэхүүн нийлүүлэх цэгээс бүрэн татан аваагүй бол талуудын гэрээнд өөрөөр заагаагүй бол хугацаа хэтэрсэн хоног тутамд татан аваагүй бүтээгдэхүүний үнийн дүнгийн 0.1%-тай тэнцэх хэмжээний алдангийг худалдагчид төлнө
Долоо.Бусад	7.1.Арилжааны гэрээтэй холбоотойгоор худалдагч, худалдан авагчийн хооронд үүссэн аливаа маргааныг зөвшилцөлд хүрч шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд зөвшилцөлд хүрээгүй бол Монгол Улсын хуулийн дагуу, Монголын Олон Улсын арбитраар, тус арбитрын дүрмийн дагуу шийдвэрлүүлнэ. 7.2. Энэхүү гэрээгээр зохицуулаагүй бусад харилцааг “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн холбогдох журмаар, журамд заагаагүй бол Монгол Улсын Иргэний хуулиар зохицуулна.

---оОо---

“Нүүрсний спот, форвард гэрээний стандарт тогтоох,
мөрдүүлэх журам”-ын Хавсралт 2

**БИРЖЭЭР АРИЛЖСАН НҮҮРСНИЙ ЭКСПОРТЫН
ИНДЕКСЭД СУУРИЛСАН ҮНЭТЭЙ ФОРВАРД ГЭРЭЭ**

“”ХК/ХХК/ТӨҮГ

“”ХК/ХХК/ТӨҮГ

Гэрээний дугаар

[2025]

**БИРЖЭЭР АРИЛЖСАН НҮҮРСНИЙ ЭКСПОРТЫН
ИНДЕКСЭД СУУРИЛСАН ҮНЭТЭЙ ФОРВАРД ГЭРЭЭ
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ОГНОО
[20-.... -....]**

ХУДАЛДАГЧ	"....." ХК/ХХК/ТӨҮГ
Хаяг:	
Утас:	
Цахим хаяг:	

ХУДАЛДАН АВАГЧ	
Хаяг:	
Утас:	
Цахим хаяг:	
Бусад холбоо барих мэдээлэл	

УДИРТГАЛ ХЭСЭГ

Энэхүү Биржээр арилжсан нүүрсний экспортын гэрээ (цаашид “**Гэрээ**” гэх)-г нэг талаас “.....” ХК/ХХК/ТӨҮГ (цаашид “**Худалдагч**” гэх), нөгөө талаас (цаашид “**Худалдан авагч**” гэх) (цаашид хамтад нь “**Талууд**” гэх) нар нь 202... оны дугаар сарын-ны өдөр “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн цахим арилжааны системд амжилттай хийгдсэн багц буюу нийт ... тонн/нүүрсний төрөл, ангилал/ (цаашид “**Нүүрс**” гэх)-ийг худалдах, худалдан авах ... дугаар хэлцлийн дагуу эрх тэгш, нээлттэй байх зарчмын үндсэн дээр дор дурдсан нөхцөлийг харилцан тохиролцож байгуулав. Үүнд:

НЭГ. ГЭРЭЭНИЙ ГОЛ НӨХЦӨЛ	
Нэг.Гэрээний хугацаа	1.1.Энэхүү Гэрээний хугацаа нь системд хэлцэл амжилттай хийгдэж, Талууд харилцан тохиролцсон хуваарийн дагуу Нүүрсийг нийлүүлж дуусах хүртэл сарын хугацаатай байна. 1.2.Гэрээний дуусгавар болох хугацаа-ны өдөр хүртэл байна.
Хоёр.Нүүрсний гарал үүсэл	2.1. Гарал үүсэл: Энэхүү Гэрээний дагуу нийлүүлэх Нүүрсийг Монгол улс, аймаг, суманд байрлах уурхайгаас (цаашид “ Уурхай ” гэх) олборлосон байна.
Гурав.Нийлүүлэх нүүрсний хэмжээ, хуваарь нүүрс нийлүүлэх цэг	3.1. Нийлүүлэх нүүрсний хэмжээ: Нэг багцын хэмжээ нь 6400 тонн байх бөгөөд энэхүү гэрээгээр багц нүүрс буюу нийт тонн Нүүрсийг нийлүүлнэ. 3.2. Худалдагч нь Гэрээний 3.1-т заасан Нүүрсийг арилжааны зард тусгасны дагуу дараах хуваарийн дагуу ачилт хийж, нийлүүлнэ. Үүнд: 3.2.1. 3.2.2. 3.3. Нүүрс нийлүүлэх цэг: Нүүрсийг DAP

	(байршил) (Инкотермс-2020)-ийн нөхцөлөөр нийлүүлнэ. 3.4. Нүүрс хүлээн авах: Худалдан авагч нь энэ гэрээний дагуу чингэлэг бэлдэх, нийлүүлэх нүүрсийг Нүүрс нийлүүлэх цэгээс 24 цагийн дотор хүлээн авах, контейнер /нүүрс/ буулгалтыг гүйцэтгэх үүрэгтэй ба ирсэн нүүрсийг цаг тухайд нь хүлээн аваагүйгээс үүдэн гарах аливаа хохирол түүний үр дагавар, Худалдагчид учирсан зардал агуулах, терминалын төлбөрийг Худалдан авагч хариуцна. 3.5 Тухайн сарын хуваарийн нийлүүлэх хэмжээ хуваарьт тусгасан хэмжээний 80 хувиас багагүй байна. 3.6 Худалдан авагч мөн тухайн сарын нийлүүлэлтийн хэмжээнд тохируулж чингэлэг нийлүүлэх үүрэгтэй.
Дөрөв.Нүүрсний чанар	4.1. Гэрээний дагуу нийлүүлэх Нүүрс нь Монгол Улсын MNS 6457:2023 “Нүүрс, нүүрсэн бүтээгдэхүүний ангилал” стандартад заасан төрөл, ангилал, чанарын үзүүлэлтэд нийцсэн байна. Худалдагчийн нийлүүлэх нүүрс нь дараах чанарын шаардлага хангасан байна. /Зард тусгагдсан чанарын үзүүлэлтүүдийг тусгана уу./ Үнслэг (хуурай,%) Дэгдэмхий бодис (үнсгүй хуурай,%) Хүхэр (хуурай, %) Нийт чийглэг (хүлээн авах үеийн төлөв,%) 4.2. Энэхүү Гэрээгээр нийлүүлэх Нүүрсний чанарыг Худалдагчийн дахь гаалийн хяналтын талбайгаас авсан нүүрсний дээжийг итгэмжлэгдсэн лаборатори (“итгэмжлэгдсэн лаборатори” гэж Гаалийн төв лаборатори эсхүл Биржийн итгэмжлэгдсэн бусад лабораторид хийгдсэн нүүрсний чанарын шинжилгээгээр тодорхойлно. 4.3. Талуудын хооронд нийлүүлсэн нүүрсний чанарын талаар маргаан үүсвэл гуравдагч дээжийг авч, нүүрсний чанарын шинжилгээг талуудын сонгосон, магадлан итгэмжлэгдсэн хөндлөнгийн лабораторид хийлгэх бөгөөд шинжилгээний үр дүнгээр маргааныг эцэслэн шийдвэрлэнэ. Хөндлөнгийн лабораторид гуравдагч дээжийн чанарыг шинжлүүлэхтэй холбогдон гарах зардлыг талууд тэнцүү хэмжээгээр хамтран хариуцна.
Тав.Үнэ болон төлбөрийн нөхцөл	5.1. Үнэ: Нүүрсний үнэ нь Биржийн арилжааны систем дээр хийгдсэн 202... оны ... дугаар сарын ...-ны өдрийн ... тоот хэлцлийн дагуу ____ юань/ам.доллар (____) байна. Энэхүү Нүүрсний үнэд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу төлөх НӨАТ ороогүй болно. 5.2. Хэрэв гэрээний хүчинтэй хугацаанд нүүрсний зах зээлийн үнэ хэлцлийн үнээс өсөх буюу буурах тохиолдолд Биржийн “Уул уурхайн бүтээгдэхүүний арилжааны журам”-ын хавсралтаар баталсан аргачлалын дагуу талууд тухайн сард нийлүүлэх бүтээгдэхүүний үнийг өмнөх сарын индексэд суурилж тооцно. 5.3. Төлбөр төлөх нөхцөл: Индексэд суурилсан үнэтэй форвард гэрээний төлбөрийг хэлцэл хийгдсэнээс хойш ажлын 10 өдрийн дотор урьдчилгаа төлбөр болох гэрээний

	нийт төлбөрийн 25%-ийг худалдагчийн дансанд шилжүүлнэ. 5.4. Худалдан авагч нь гэрээний үлдэгдэл төлбөр болох сар бүр ачилтад ногдох төлбөрийг худалдагчаас ирүүлсэн нэхэмжлэх хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор төлөх эсхүл банкны аккредитив (LC)-ээр төлж болно. 5.5. Арилжааны зард тусгасан нөхцөлөөр төлбөр төлөгдсөнөөр нийлүүлэлт хийгдэж эхэлнэ. 5.6. Чанарын зөрүүнд тооцох үнийн нэмэгдэл, бууралт байгаа тохиолдолд түүнийг тооцох аргачлал. Тийм / Үгүй. Хэрэв тийм бол аргачлалаа тодорхой бичих Аргачлал:..... Дээрх гэрээний төлбөрийг Худалдагчийн банкин дахь нэрийн дансанд шилжүүлнэ. Худалдагчийн дансны мэдээлэл: Хүлээн авагч: ХХК/ХКТӨҮГ Хүлээн авагчийн хаяг: Монгол улс,хот/аймаг, дүүрэг/сум, байр,..... давхар Хүлээн авагчийн банк: банк Банкны хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, дүүрэг,байр Swift код: Дансны дугаар:
Зургаа. Хариуцлага	6.1. Худалдагч нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээнд заасан хугацаанд зохих бүтээгдэхүүнийг нийлүүлэх цэгт бүрэн хүргээгүй тохиолдолд гэрээнд өөрөөр заагаагүй бол хугацаа хэтэрсэн хоног тутамд нийлүүлэх цэгт хүргээгүй бүтээгдэхүүний үнийн дүнгийн 0.1%-тай тэнцэх алдангийг худалдан авагчид төлнө. 6.2. Худалдан авагч нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээнд заасан хугацаанд худалдан авсан бүтээгдэхүүнээ бүтээгдэхүүн нийлүүлэх цэгээс бүрэн татан аваагүй (арилжааны зард чингэлэг бэлдэх үүргийг худалдан авагчид тусган ирүүлсэн) бол талуудын гэрээнд өөрөөр заагаагүй бол хугацаа хэтэрсэн хоног тутамд татан аваагүй бүтээгдэхүүний үнийн дүнгийн 0.1%-тай тэнцэх хэмжээний алдангийг худалдагчид төлнө.
Долоо.Бусад	7.1. Арилжааны гэрээтэй холбоотойгоор худалдагч, худалдан авагчийн хооронд үүссэн аливаа маргааныг зөвшилцөлд хүрч шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд зөвшилцөлд хүрээгүй бол Монгол Улсын хуулийн дагуу, Монголын Олон Улсын арбитраар, тус арбитрын дүрмийн дагуу шийдвэрлүүлнэ. 7.2. Энэхүү гэрээгээр зохицуулаагүй бусад харилцааг "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн холбогдох журмаар, журамд заагаагүй бол Монгол улсын холбогдох бусад хуулиар зохицуулна.

---oOo---

“Нүүрсний спот, форвард гэрээний стандарт
тогтоох, мөрдүүлэх журам”-ын Хавсралт 3

**БИРЖЭЭР АРИЛЖСАН НҮҮРСНИЙ ЭКСПОРТЫН
ТОГТМОЛ ҮНЭТЭЙ ФОРВАРД ГЭРЭЭ**

“ ” ХК/ХХК/ТӨҮГ

“ ” ХК/ХХК/ТӨҮГ

Гэрээний дугаар

[2025]

**БИРЖЭЭР АРИЛЖСАН НҮҮРСНИЙ ЭКСПОРТЫН
ТОГТМОЛ ҮНЭТЭЙ ФОРВАРД ГЭРЭЭ
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ОГНОО
[20-....-....]**

ХУДАЛДАГЧ	"....." ХК/ХХК/ТӨҮГ
Хаяг:	
Утас:	
Цахим хаяг:	

ХУДАЛДАН АВАГЧ	
Хаяг:	
Утас:	
Цахим хаяг:	
Бусад холбоо барих мэдээлэл	

УДИРТГАЛ ХЭСЭГ

Энэхүү Биржээр арилжсан нүүрсний экспортын гэрээ (цаашид “Гэрээ” гэх)-г нэг талаас “.....” ХК/ХХК/ТӨҮГ (цаашид “Худалдагч” гэх), нөгөө талаас (цаашид “Худалдан авагч” гэх) (цаашид хамтад нь “Талууд” гэх) нар нь 202... оны дугаар сарын-ны өдөр “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн цахим арилжааны системд амжилттай хийгдсэн багц буюу нийт ... тонн/нүүрсний төрөл, ангилал/ (цаашид “Нүүрс” гэх)-ийг худалдах, худалдан авах ... дугаар хэлцлийн дагуу эрх тэгш, нээлттэй байх зарчмын үндсэн дээр дор дурдсан нөхцөлийг харилцан тохиролцож байгуулав. Үүнд:

НЭГ. ГЭРЭЭНИЙ ГОЛ НӨХЦӨЛ	
Нэг.Гэрээний хугацаа	1.2.Энэхүү Гэрээний хугацаа нь системд хэлцэл амжилттай хийгдэж, Талууд харилцан тохиролцсон хуваарийн дагуу Нүүрсийг нийлүүлж дуусах хүртэл хоногийн хугацаатай байна. 1.3.Гэрээний дуусгавар болох хугацаа-ны өдөр хүртэл байна.
Хоёр.Нүүрсний гарал үүсэл	2.1. Гарал үүсэл: Энэхүү Гэрээний дагуу нийлүүлэх Нүүрсийг Монгол улс, аймаг, суманд байрлах уурхайгаас (цаашид “Уурхай” гэх) олборлосон байна.
Гурав.Нийлүүлэх нүүрсний хэмжээ, хуваарь нүүрс нийлүүлэх цэг	3.1. Нийлүүлэх нүүрсний хэмжээ: Нэг багцын хэмжээ нь 6400 тонн байх бөгөөд энэхүү гэрээгээр багц нүүрс буюу нийт тонн Нүүрсийг нийлүүлнэ. 3.2. Худалдагч нь Гэрээний 3.1-т заасан Нүүрсийг арилжааны зард тусгасны дагуу дараах хуваарийн дагуу ачилт хийж, нийлүүлнэ. Үүнд: 3.2.1. 3.2.2. 3.3. Нүүрс нийлүүлэх цэг: Нүүрсийг DAP

	(байршил) (Инкотермс-2020)-ийн нөхцөлөөр нийлүүлнэ. 3.4. Нүүрс хүлээн авах: Худалдан авагч нь энэ гэрээний дагуу чингэлэг бэлдэх, нийлүүлэх нүүрсийг Нүүрс нийлүүлэх цэгээс 24 цагийн дотор хүлээн авах, контейнер /нүүрс/ буулгалтыг гүйцэтгэх үүрэгтэй ба ирсэн нүүрсийг цаг тухайд нь хүлээн аваагүйгээс үүдэн гарах аливаа хохирол түүний үр дагавар, Худалдагчид учирсан зардал агуулах, терминалын төлбөрийг Худалдан авагч хариуцна.
Дөрөв.Нүүрсний чанар	4.1. Гэрээний дагуу нийлүүлэх Нүүрс нь Монгол Улсын MNS 6457:2023 “Нүүрс, нүүрсэн бүтээгдэхүүний ангилал” стандартад заасан төрөл, ангилал, чанарын үзүүлэлтэд нийцсэн байна. Худалдагчийн нийлүүлэх нүүрс нь дараах чанарын шаардлага хангасан байна. /Зард тусгагдсан чанарын үзүүлэлтүүдийг тусгана уу./ Үнслэг (хуурай,%) Дэгдэмхий бодис (үнсгүй хуурай,%) Хүхэр (хуурай, %) Нийт чийглэг (хүлээн авах үеийн төлөв,%) 4.2. Энэхүү Гэрээгээр нийлүүлэх Нүүрсний чанарыг Худалдагчийн дахь гаалийн хяналтын талбайгаас авсан нүүрсний дээжийг итгэмжлэгдсэн лаборатори (“итгэмжлэгдсэн лаборатори” гэж Гаалийн төв лаборатори эсхүл Биржийн итгэмжлэгдсэн бусад лабораторид хийгдсэн нүүрсний чанарын шинжилгээгээр тодорхойлно. 4.3. Талуудын хооронд нийлүүлсэн нүүрсний чанарын талаар маргаан үүсвэл гуравдагч дээжийг авч, нүүрсний чанарын шинжилгээг талуудын сонгосон, магадлан итгэмжлэгдсэн хөндлөнгийн лабораторид хийлгэх бөгөөд шинжилгээний үр дүнгээр маргааныг эцэслэн шийдвэрлэнэ. Хөндлөнгийн лабораторид гуравдагч дээжийн чанарыг шинжлүүлэхтэй холбогдон гарах зардлыг талууд тэнцүү хэмжээгээр хамтран хариуцна.
Тав.Үнэ болон төлбөрийн нөхцөл	5.1. Үнэ: Нүүрсний үнэ нь Биржийн арилжааны систем дээр хийгдсэн 202... оны ... дугаар сарын ...-ны өдрийн ... тоот хэлцлийн дагуу ____ юань/ам.доллар (____) байна. Энэхүү Нүүрсний үнэд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу төлөх НӨАТ ороогүй болно. 5.2.Төлбөр төлөх нөхцөл: Худалдан авагч нь гэрээ байгуулснаас хойш Худалдагчийн ирүүлсэн нэхэмжлэхийн дагуу төлбөрийг ажлын 10 өдрийн дотор шилжүүлнэ. Дээрх гэрээний төлбөрийг Худалдагчийн банкин дахь нэрийн дансанд шилжүүлнэ. Худалдагчийн дансны мэдээлэл: Хүлээн авагч: ХК/ХХК/ТӨҮГ Хүлээн авагчийн хаяг: Монгол улс,хот/аймаг, дүүрэг/сум, байр,..... давхар Хүлээн авагчийн банк: банк Банкны хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, дүүрэг,байр Swift код: Дансны дугаар:

Зургаа. Хариуцлага	6.1. Худалдагч нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээнд заасан хугацаанд зохих бүтээгдэхүүнийг нийлүүлэх цэгт бүрэн хүргээгүй тохиолдолд гэрээнд өөрөөр заагаагүй бол хугацаа хэтэрсэн хоног тутамд нийлүүлэх цэгт хүргээгүй бүтээгдэхүүний үнийн дүнгийн 0.1%-тай тэнцэх алдангийг худалдан авагчид төлнө. 6.2. Худалдан авагч нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээнд заасан хугацаанд худалдан авсан бүтээгдэхүүнээ бүтээгдэхүүн нийлүүлэх цэгээс бүрэн татан аваагүй (<i>арилжааны зард чингэлэг бэлдэх үүргийг худалдан авагчид тусган ирүүлсэн</i>) бол талуудын гэрээнд өөрөөр заагаагүй бол хугацаа хэтэрсэн хоног тутамд татан аваагүй бүтээгдэхүүний үнийн дүнгийн 0.1%-тай тэнцэх хэмжээний алдангийг худалдагчид төлнө.
Долоо.Бусад	7.1.Арилжааны гэрээтэй холбоотойгоор худалдагч, худалдан авагчийн хооронд үүссэн аливаа маргааныг зөвшилцөлд хүрч шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд зөвшилцөлд хүрээгүй бол Монгол Улсын хуулийн дагуу, Монголын Олон Улсын арбитраар, тус арбитрын дүрмийн дагуу шийдвэрлүүлнэ. 7.2. Энэхүү гэрээгээр зохицуулаагүй бусад харилцааг "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн холбогдох журмаар, журамд заагаагүй бол Монгол Улсын холбогдох бусад хуулиар зохицуулна.

---oOo---

